MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,153.465... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.07.17. Даваа. №131, 132 (4745, 4746) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +26

Шөнө +17

**УЛС ТӨР**

ТҮЙМРИЙН АСУУДЛААР УЛСЫН ОНЦГОЙ КОМИСС ХУРАЛДАВ

IV нүүрт

**ГОВЬСҮМБЭРИЙН МЭДЭЭ**

БОРЖИГИН ТҮМНИЙ ДЭЛГЭР САЙХАН НААДАМ...

IX нүүрт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# Х.БАТТУЛГА: ЭНЭ ЦАГААС ЭХЛЭН МОНГОЛ УЛСАА БҮТЭЭГЧ, ҮЙЛДВЭРЛЭГЧ ОРОН БАЙЛГАХЫН ТӨЛӨӨ АЖИЛДАА ШУУРХАЙЛАН ОРНО



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

Э.ЭНХЦЭЦЭГ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль анх удаа хоёр шатны санал хураалтын дунд явагдаж өндөрлөлөө. Эхний санал хураалтаар АН-аас нэр дэвшигч Х.Баттулга 517 478 санал цуглуулж ялалт байгуулсан бол МАН-аас нэр дэвшигч М.Энхболд 411 748, МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар 409 899 санал авсан. Иймхүү СЕХ-оос хоёр дахь шатны санал хураалтыг явуулахаар болсноо зарлаж, 2017 оны долдугаар сарын 07-ны өдөр хоёр нэр дэвшигчийн дунд дахин санал хураалт явагдаж, АН-аас нэр дэвшигч Халтмаагийн Баттулга нийт санал өгсөн сонгогчдын олонхийн саналыг авснаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон юм.

**Үргэлжлэл нь II-III нүүрт**

Дугаарын 60 мөр

## Найр наадмаа өндөрлөж, намрын ажилдаа оръё

Н.БАТЗАЯА

Наадмын маргааш намар гэж нэг үг бий. Эртнээс уламжилж ирсэн энэ үг зүгээр ч нэг гараагүй биз ээ. Хөхөөн дуу ойртсоныг илтгэх энэ үгийг дахин дахин хэлмээр байна. Намрын ажил нуруун дээр ирлээ, одоо найр наадмаа өндөрлөе. Яах вэ, өвөлжин, хаваржин ажилласан хүмүүс зуны налгар цагт зугаалан, Үндэсний уламжлалт найр наадмаа тэмдэглэх нь зүйн хэрэг. Гэхдээ найр наадмаа өндөрлөх цаг аль хэдийнэ болжээ. Баяр наадам хэмээн хөл алдаж байх хооронд Сэлэнгэ аймгийн Ерөө, Мандал сумдад тус бүр гурав, Хүдэр суманд хоёр, Төв аймгийн Батсүмбэр суманд дөрвөн түймэр, нийтдээ 12 түймэр гарчээ.

**Төгсгөл нь III нүүрт**

ОНЦЛОХ МЭДЭЭ

## ОХУ-ын Онцгой байдлын яам дэмжлэг үзүүлэхээ илэрхийллээ

Олон нийтийн зүгээс түймэр унтраах нисдэг тэрэг, онгоц авах санаачилгыг гаргаж, хандивын аян эхлүүлээд байгаа билээ. Гэвч хүн хүч хүрэлцээтэй хэдий ч түймрийн зарим голомтод хүрч чадахгүй, нисдэг тэрэг шаардлагатай байгаа талаар мэдээлж буй. Тэгвэл дөнгөж сая хуралдсан Улсын онцгой комиссын хуралдаанаар түймрийн байдал, авах арга хэмжээний талаар хэлэлцлээ. Энэ үеэр ОБЕГ-аас ОХУ-ын Онцгой байдлын яамны холбогдох удирдлагуудтай холбогдон түймэр унтраах ажиллагаанд агаараас түймэр унтраахад дэмжлэг үзүүлэх хүсэлт гаргасан тухай мэдээллээ. Уг хүсэлтийн дагуу ОХУ-ын Онцгой байдлын яам дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн бөгөөд Сибирийн мужийн онцгой байдлын газартаа чиглэл өгсөн байна. Сибирийн мужийн онцгой байдлын газраас өнөөдөр хариу өгч, агаараас түймэр унтраах нөхцөл бүрдэх байх хэмээн ОБЕГ-ын дарга мэдээлэлдээ дурьдлаа. Мөн ЗТХ-ийн сайд ч холбогдох техник хэрэгслээр хангаж болохоо мэдэгдэж байлаа. Зам, тээврийн хөгжлийн яам нэр бүхий хоёр аж ахуйн нэгжийн онгоцыг ашиглах талаар тохиролцоонд хүрчээ. Эдгээр онгоц нэг удаагийн нислэгээр 1-2 тонн ус тээвэрлэн түймрийн голомтод цацах боломжтой юм байна.

ХҮМҮҮС



## Ч.ТҮМЭНБАЯР: УЛСЫН НААДАМД МОРЬДЫНХОО ТООСЫГ ҮЗЭХ Л МИНИЙ ЖАРГАЛ

Б.ДАВААХҮҮ

*Алдарт Донойн хөндийг Төв аймгийнхан андахгүй. Үе үеийн хурдан хүлгүүдийн шандасыг сорьдог энэ хөндий уяач хийгээд хурдан хүлгүүдэд хишиг буянаа хайрласаар иржээ. Улсын баяр наадамд шандаст хурдан хүлгүүдийнхээ тоосыг үзэхээр мэрийж буй Ч.Түмэнбаяр, Х.Баярбат нарын хурдан буян их сунгаанд өнгөлж, уяач эздээ баярлуулж байх торгон мөчийг уншигч тантай хуваалцая. Хэдийгээр улсын их баяр наадам өндөрлөж, аймаг, сумдын наадмын тоос айсуй энэ цаг дор уяач бүхний уясан хүлгүүд хурдан байх болтугай. "Хэрэвзээ би номын мөр хөөгөөгүйсэн бол аав шигээ шаггүй уяач болсон байх биз. Гэхдээ цаг хугацаа оройтдоггүй аж. Адуун сүрэг рүүгээ ойртох тусам сэтгэл хөнгөрч сайхан болдог хэмээн хуучлах эрхэм бол Ч.Түмэнбаяр гуай. Аж үйлдвэр, уул уурхайн салбарт өөрийн орон зайг баттай эзэлсэн түүнтэй хурдан хүлгийнх нь уяан дээр ярилцсан юм. Намайг эдүгээ залуу уяач гэх нь хаашаа юм хэмээн хэнэгүйхэн инээх түүнтэй ярилцахад сонирхолтой байлаа.*

**Төгсгөл нь VI-VII нүүрт**

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## ОБЕГ-аас түймрийн голомт руу явахгүй байхыг анхааруулав

Ойн түймрийн нөхцөл байдал хүндхэн байгаа тухай мэдээлэл сонссон иргэд хандивын ажил зохион байгуулж, мөн залуусыг сайн дураар гал түймэр унтраах ажилд нэгдээд байгаа. Харин гал түймэр унтраахаар иргэд сайн дураар явахыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэнэ. Зайлшгүй явах тохиолдолд мэргэжлийн нэг өдрийн сургалтад хамрагдаж, эрүүл мэндээр тэнцэх эсэхээ заавал шалгуулах, мэргэжлийн хүмүүсийн зааварчилгааны дагуу ажиллах ёстойг анхааруулаа. "Төр иргэнээ хамгаалах ёстой. Тийм учраас иргэдийн энэ эх орноо гэсэн сайхан санаачилгыг талархан хүлээж авч байгаа хэдий ч түймрийн нөхцөл байдал тогтворгүй байгаа ийм нөхцөлд мэргэжлийн бус хүмүүсийг ойн түймэрт явуулж болохгүй. Иргэдийнхээ амь нас, аюулгүй байдлыг хамгаалах ёстой" гэсэн байр суурийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагаас баримталж байгааг албаныхан хэллээ. "Гал сөнөөгчдөд туслах групп"-ийн төлөөллүүд сайн дураар явна гээд хамаг юмаа бэлтгээд ирсэн хүмүүсийг тараах хэцүү байгаа тул мэргэжил арга зүйн зөвлөгөө, удирдлагаар хангаж өгөхийг хүсэв. Мөн түймрийн голомт руу оролгүй, боломжит газар хүртэл ус зөөх, хоол унд хийж хүргэж өгөх гэх мэтээр ажиллах нөхцөл боломжийг гаргаж өгөхийг хүслээ гэж Онцгой байдлын ерөнхий газраас мэдээллээ.

**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2395.00 | 2414.00 | ФУНТ | 3099.00 | 3199.00 |
| ЕВРО | 2726.00 | 2788.00 | РУБЛЬ | 39.80 | 41.80 |
| ИЕН | 21.21 | 21.67 | ЮАНЬ | 353.50 | 357.10 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2390.00 | 2410.00 | ФУНТ | 3110.00 | 3192.00 |
| ЕВРО | 2721.00 | 2794.00 | РУБЛЬ | 39.48 | 42.07 |
| ИЕН | 21.08 | 21.68 | ЮАНЬ | 352.00 | 356.50 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

УЛС ТӨР

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# Х.БАТТУЛГА: ЭНЭ ЦАГААС ЭХЛЭН МОНГОЛ ОРОН БАЙЛГАХЫН ТӨЛӨӨ АЖИЛДАА



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

## Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулгын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөв

Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн хоёр дахь шатны санал хураалтын дүнг нэгтгэж, энэ сарын 10-ны өдөр Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулж, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх тов тогтоох тухай” УИХ-ын тогтоолын төслийг чуулганы хуралдаанд бэлтгэн шилжүүлэхээр хэлэлцэв. Байнгын хорооны хуралдааны дараа УИХ-ын ээлжит бус чуулган хуралдаж, дээрх тогтоолын төслийг хэлэлцлээ. Чуулганы хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн хоёр дахь санал хураалтад сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчдын 60.67 хувь нь саналаа өгч, нэр дэвшигч Халтмаагийн Баттулга 50.61 хувь буюу олонхийн санал авсан тул Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн 96.5 хувь нь дэмжин, батлав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх өдөр, цагийг 2017 оны долдугаар сарын 10-ны өдөр байхаар тогтоолоо.

MMINFO.
МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012
Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510
Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.**
**2 давхар. 209, 211 тоот**

**“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

## Ц.Элбэгдорж: Монголын ард түмнийг хайрлаж яваарай

Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчийн тангараг өргөх өдөр Төрийн далбааны өдөртэй давхцан тохиосон бөгөөд Төрийн далбааны өдөрт зориулсан хүндэтгэлийн ёслолын ажиллагаа Сүхбаатарын талбайд боллоо. Ёслолын ажиллагааг нээж, Монгол Улсын дөрөв дэх Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний командлагч Ц.Элбэгдорж үг хэлсэн юм. Тэрбээр Төрийн далбааны өдрийг тэмдэглэх болсны ач холбогдлыг дурьдаад "Эрх чөлөөний хүч өөд өө. Ард түмний ухаанаар жигүүрлэсэн миний Монголын ирээдүй өөдрөг байна" гэдгийг онцолсон юм. Үүний дараа Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын ажиллагаа эхэлсэн. Энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Намайг төрийн тэргүүнээр залж, итгэл хүлээлгэж, хамтарч дэмжиж ажилласан ард түмэндээ хязгааргүй талархаж байна. Төрийн алба хаагчид Монголын ард түмнийг хайрлаж яваарай. Би сайн ажилласан бол ард түмний хүч, хэрэв би муу ажилласан бол миний муугийнх юм шүү. Намайг дэмжиж ажилласан Ерөнхийлөгчийн Тамгын газрынхандаа талархаж байна. Монгол бол нэг баг юм. Энэ багийн төлөө, Монголын сайн сайхны төлөө өөрт байгаа бүхнийг зориулах болно. Та бүхэн сайхан наадаарай” гэв. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөж, Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүллээ. Энэ үеэр мөн өмнөх Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийг Сүхбаатарын талбайн төв хэсэг хүртэл хүндэтгэн гаргаж өгөв.

## Х.Баттулга: Би иргэдээ сонсдог, иргэдтэйгээ хамтран ихийг бүтээдэг Ерөнхийлөгч байна

Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчөөр сонгогдсон Халтмаагийн Баттулга Төрийн ордны их танхимд тангараг өргөж, ард түмэндээ хандан үг хэллээ. Тэрбээр “Миний бие иргэдийнхээ итгэлийг хүлээж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөлөө. Энэ бол иргэд, сонгогчдоос надад хүлээлгэж буй их итгэл найдвар, өндөр хариуцлага бөгөөд би Ерөнхийлөгчийн албыг өвөг дээдсээс уламжлан ирсэн төрт ёсны нандин хэлхээ, ард түмнийхээ төлөө сэтгэл оюунаа дайчлан чин шударгаар зүтгэх дуудлага хэмээн хүлээн авч байна. Итгэл өгч, найдан дэмжиж, Монгол Улсаа хөгжүүлэн дэвжээх мөрийн хөтөлбөрийг минь дэмжсэн нийт иргэддээ халуун талархал илэрхийлье. Мөн хамтран өрсөлдөж, Монгол Улс дахь ардчилсан сонголтыг хүлээн зөвшөөрсөн өрсөлдөгчиддөө Монголын төлөөх цаашдынх нь үйл хэрэгт амжилт хүсье. Мөн энэ мөчид Монгол Улсын Ерөнхийлөгчөөр хоёронтоо сонгогдон ажилласан Цахиагийн Элбэгдорж Ерөнхийлөгчийн цаашдынх нь ажил үйлсэд амжилт хүсье. Өнөөдөр Монголын ард түмэнд олон төрлийн хүлээлт байна. Шийдлээ хүлээсэн олон сорилтууд ар араасаа бодлого нэхэж, хамтын ажиллагаа, хөдөлмөр зүтгэл, эх оронч сэтгэл шаардаж байна. Олон түмний хүлээлт бол хийх ажлын минь замын зураг болж, түүнийг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх нь надад оногдсон үүрэг гэж ойлгож байна. Миний бие, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчаар Та бүхнийхээ итгэл дэмжлэгээр сонгогдож, дөнгөж сая Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу тангаргаа өргөлөө. Та бүхнийхээ өндөр итгэлийг би, шаргуу зүтгэлээр хариулан ажиллахаа энд дахин тангараглаж байна.

**Их хурлын Эрхэм гишүүд ээ,**

Та биднийг хойшлуулшгүй шийдэх ёстой ажлууд шилээ даран хүлээж байна. Би нэн тэргүүнд иргэдээ ядуурлаас гаргах, ажилгүйдлийг арилгахын төлөө та бүхэнтэй хамтран ажиллахыг эрмэлзэж байна. Өнөөдөр ядуурал, ажилгүйдэл нь ноцтой хэмжээнд ирж, Үндэсний “аюултай” байдалд хүрчихээд байгаад би онцгой анхаарч бүх боломж, бололцоог үүнд чиглүүлэн, төвлөрч ажиллах болно. Энэ зорилгын төлөө Засгийн газар, УИХ-тай хамтарч, нэгэн хүчээр үр дүнд хүрэхийг зорих болно гэдгээ та бүхэнд дуулгая. Хамтын хүч ямагт амжилт авчирдаг. Та бүхний зөв шийдвэр, зөв бодлого бүрийг би дэмжин ажиллах болно. Ард түмний эрх ашгийг огоорсон, дутуу дулимаг боловсруулсан бодлого, шийдвэр, хууль тогтоомж гаргаваас засах, залруулахын төлөө шаардаж, шүүмжлэх болно.

**Монголчууд аа, Ахан дүүс ээ,**

Би иргэдээ сонсдог, иргэдтэйгээ хамтран ихийг бүтээдэг Ерөнхийлөгч байна. Монгол Улс богино хугацаанд





эдийн засгийн бодит өсөлтийг бий болгосон, дэлхийд нэртэй, дотоодын үйлдвэрлэл хөгжсөн, иргэдийн маань бүтээмж нэмэгдсэн улс орныг иргэдийнхээ оролцоотой цогцлоож чадна гэдэгт итгэл төгс байна. Миний бие ажлын зарчимдаа дараах зүйлийг дэмжихгүй гэдгээ энд бас онцлон хэлье. Хууль ёсыг уландаа гишгэсэн, хуйвалдаанч түшмэдийн бодлогыг дэмжихгүй. Тэдний бусармаг үйлдлийг хуулийн дагуу таслан зогсооно. Төрийн албыг наймаалдаг, аливаа төрлийн гэмт үйлдэлтэй шийдвэртэй тэмцэнэ. Иргэдээ ядууруулж, цөөн хүний халаас зузаардаг бурангуй ёсыг таягдан хаяна. Хүний эрхийг хөсөрдүүлдэг, иргэдээ ялгаварладаг харгис жишгийг халах болно.

-Би эв нэгдлийг эрхэмлэж, үндэсний эрх ашгаа дээдэлсэн Ерөнхийлөгч байна.

-Би эрх чөлөө, шударга ёсыг сахин хамгаалж, иргэнээ дээдэлсэн Ерөнхийлөгч байна.

-Би эдийн засгаа сэргээж, аж үйлдвэрийг хөгжүүлсэн Ерөнхийлөгч байна.

-Би экологийн тэнцвэрийг хангаж, газар нутгаа хамгаалсан Ерөнхийлөгч байна.

-Би экспортын шинэ эринийг эхлүүлсэн, эрх тэгш гадаад харилцааг эрхэмлэгч Ерөнхийлөгч байна.

Энэ цагаас эхлэн Монгол Улсаа бүтээгч орон, үйлдвэрлэгч улс, хамтрагч үндэстэн байлгахын төлөө, ажилдаа шуурхайлан орно оо. Мөнхийн хоёр хөрш ОХУ, БНХАУ-тай найрамдалт сайн хөршийн харилцаагаа бүх талбарт тэлж, гуравдагч хөршийн бодлого дээр онцгой анхаарал хандуулна. Монголын маргаашийг, эх орныхоо хөгжлийн замыг алс харж чаддаг, түүний төлөө сайн үйлсийг дэлгэрүүлдэг, хамтарч чаддаг Ерөнхийлөгч байна.

Мөнх тэнгэр биднийг ивээг, сайн бүхэн дэвжин дэлгэрэх болтугай. Дээдсийн хийморь сүлд биднийг уриалан дуудаг, Монгол Улс хөгжин бадартугай” гэсэн юм.

## Шинэ Ерөнхийлөгчийн анхны зарлиг

Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн ажилдаа орж, анхны зарлигаа гаргасан бөгөөд Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаараа УИХ-ын дарга асан З.Энхболдыг томиллоо. Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга З.Энхболд нь 2005-2016 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2012-2016 онд Монгол Улсын Их Хурлын даргаар ажиллаж байсан билээ.

## Ерөнхийлөгч Элчин сайдуудыг хүлээн авч уулзлаа

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Европын холбооноос Монгол Улсад суугаа Элчин сайд Ханс Дийтмар Швайсгутыг хүлээн авч уулзлаа. Элчин сайд Ханс Дийтмар Швайсгут уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад баяр хүргэж, Европын зөвлөлийн Ерөнхийлөгч, Европын комиссын Ерөнхийлөгч нарын баяр хүргэсэн мэндчилгээг уламжлав. Уулзалтаар Монгол Улс, Европын холбооны хоорондын хамтын ажиллагаа, харилцааг өргөжүүлэн гүнзгийрүүлэх талаар ярилцсан юм. Мөн энэ өдөр Япон Улсын Ерөнхий сайдын бие төлөөлөгч, Японы парламент дахь Япон, Монголын найрамдлын бүлгийн дарга М.Хаяаши тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан. Япон Улсын Ерөнхий сайд Ш.Абэ-гийн бие төлөөлөгч М.Хаяаши уулзалтын эхэнд ноён Ш.Абэ-гийн баяр хүргэсэн мэндчилгээг Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад гардуулан өгөв. Уулзалтын үеэр тэд хоёр талын харилцааны асуудлуудаар санал солилцон

# УЛСАА БҮТЭЭГЧ, ҮЙЛДВЭРЛЭГЧ ШУУРХАЙЛАН ОРНО

ярилцлаа. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга БНХАУ-ын даргын бие төлөөлөгч, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шин Хайминийг хүлээн авч уулзсан. Уулзалтын эхэнд БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шин Хаймин БНХАУ-ын дарга Си Зиньпинээс Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад Ерөнхийлөгчөөр сонгогдсонд нь баяр хүргэсэн захидлыг гардуулан өгсөн юм. Уулзалтаар Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шин Хаймин нар хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны сэдвүүдээр ярилцлаа.

### Монгол Улсын Ерөнхийлөгчид баярын захидлууд ирэв

Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчөөр Халтмаагийн Баттулга сонгогдсоны дараа түүнд улс, орны төрийн тэргүүнүүдээс баярын захидлууд ирсээр байв. Хамгийн түрүүнд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин баярын захидал илгээсэн бол АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп, БНСУ-ын Ерөнхийлөгч Мүн Жэ Ин, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын

Ардын Дээд Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ким Ен Нам, Кувейт улсын Эмир Сабах Аль-Ахмад Аль-Жабер Аль-Сабах нар баярын цахилгаан илгээсэн юм.

### Ерөнхийлөгчийн зөвлөхүүд томилогдоно

Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлээд удаагүй байна. Харин өнөөдрөөс Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөхүүд томилогдон ажилдаа орно. Шинэ Ерөнхийлөгчид хэн зөвлөх вэ гэдэг зөвхөн Ардчилсан намын гишүүдийн анхаарлыг татаж буй бус олон нийтийн хамгийн их сонирхож буй асуудал юм.



Дугаарын 60 мөр

## Найр наадмаа өндөрлөж, намрын ажилдаа оръё

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Одоогийн байдлаар гурван түймрийг цурманд оруулж, есөн түймэр асч байгаа талаар Онцгой байдлын албаны сайтад мэдээлж байгаа билээ. Түүнээс гадна Онцгой байдлын газраас хориглосоор байхад түймэртэй ч нүүр тулж үзээгүй залуус сэтгэл хөдлөлдөө автан галын голомтод очиж, өөрсдийн биеэр туслахаар явсан. Харамсалтай нь тэдний зарим нь угаартаж, бүр модонд хүртэл даруулсан гэх мэдээлэл байна. Түймрийн талаар анхны ч мэдэгдэхүүн байхгүй залуус дарь нь дээр давс гэгчээр онцгойгийн алба хаагчдад ёстой л нэрмээс болж байгаа аж. Иргэд хэцүү цагт эх орныхоо төлөө сэтгэл гарган нэгдэж, тусламжийн гараа сунгаж буй нь сайхан хэрэг. Гэхдээ түймэр гарч байгаа газар очиж, амь насаа эрсдэлд оруулах нь мэргэжлийн хүмүүст улам л төвөг удахын нэмэр. Уг нь онцгой байдлынхан гал унтраах гэж ирээд угаартаж, бэртэж, гэмтсэн иргэдтэй зууралдаж байхын оронд түймрээ жаахан ч гэсэн унтрааж байвал сайнсан. Тэглээ ч ОБЕГ-аас одоогийн байдлаар хүн хүч дутагдаагүй, шаардлагатай тохиолдолд Зэвсэгт хүчний анги нэгтгэлийг дайчилна хэмээн мэдэгдсэн. Тиймээс найр наадмаа өндөрлөж, ядаж л эхний удаад түймрийг унтраах арга хэмжээ авбал дээрсэн. Харин дараагийн ээлжинд биднийг хахир өвлийг өнөтэй давах хадлан бордоогоо бэлтгэх, улсын нөөцийн санг бүрдүүлэх гээд том ажил хүлээж байна.

Хатуухан өвөлтэй нүүр тулдаг манайх шиг орон эртхэн л хадлан бордоогоо нөөцлөхгүй бол хөхөө өвлийн зуданд хамаг малаа алдаад дуусна. Түүнээс гадна нийслэлчүүдэд дулаан, эрчим хүчээ нөөцлөх, түлээ түлшээ бэлтгэх зэрэг багагүй ажил бий. Энэ их ажил улсын баяр наадам, түүний араас үргэлжлэх аймаг, сумын наадмын тоосонд дарагдаж, мартагдах нь. Дээдэс, доодосгүй энд тэнд сайхан аялж, зугаалсан зургаа цахим ертөнцөд гайхуулж, энэ зуны наадам сайхан болж буйг шагшицгааж байна. Арга ч үгүй биз, Ерөнхийлөгчийн сонгуульд ээрэгдэн удаан хүлээлгэсэн наадам юм хойно сүржин тэмдэглэх нь мэдээжийн хэрэг. Гэхдээ намрын налгар өдрүүд наашилж эхэллээ. Нэг л мэдэхэд өвөл хаянд ирчихнэ.

Жил бүрийн өвөл хэдэн малчид нь өвс, тэжээлгүй хэмээн гадна, дотноос тусламж, дэмжлэг гуйж зогсдог увайгүй суртлыг арилгах цаг болсон баймаарсан. Эрт цагт хүн бүр эрхэлсэн ажилдаа үнэнч хандаж, хадлан тэжээлдээ эртлэн гардаг байсан. Нэг үгээр хэлбэл, найр наадмаа ч, ажил үйлсээ ч сайн хийж чаддаг байж. Орчин цагт энэ сайхан уламжлал алдагдаж, найр наадам эхлэхээр хэзээ дуусахаа мэдэгдэхгүй, нэг л амар амгалан хүмүүс байх болжээ. Аливаа зүйл хэмжээ хязгаартай байхдаа сайхан. Ихдэх эсвэл багадвал ямар нэгэн балаг тарьдаг жамтай. Тиймээс дахин хэлье. Наадмын маргааш намар. Тиймээс намаржин хавтгайрдаг найр наадмаа өндөрлөж, хахир өвөлдөө бэлдэцгээе.

ӨӨР ӨНЦӨГ

# МАН задарч, АН эвлэлдэж эхэллээ




**Нэг. МАН**

Анх удаа МАН-ын дарга Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөөд унав. Дахин санал хураалтын дүн гарч, АН-ын Х.Баттулга Ерөнхийлөгч болсноос хойш МАН-ынхан М.Энхболдыг сонгуульд унагасан буруутны эрэлд гарчээ. Буруутай эзнийг наадмын өдрүүдэд ч “эрж хайсаар” олж илрүүлсэн мэдээлэл байна.

МАН-ын дарга М.Энхболдыг энэ сонгуульд ялагдахад хамгийн том нөлөө үзүүлсэн нь 60 тэрбумыг босгох тухай бичлэг гэж намынхан нь үзжээ. Энэ бичлэгийг МАН-ынхан “Бичлэг биш эвлүүлэг” гэж удаа дараа мэдэгдэж, хуулийн байгууллагаар “Эвлүүлэг байна” гэсэн дүгнэлт гаргуулсан ч ард түмэн үүнийг бодит ярианы бичлэг гэдэгт итгэдэг. Тиймээс МАН-ынхан энэ бичлэгт оролцсон нөхдүүдэд хариуцлага тооцох талаар нэлээд дээд түвшиндөө яриад эхэлсэн байна.

Наадмын өмнөхөн МАН-ын Удирдах зөвлөл, УИХ дахь МАН-ын бүлгийн өргөтгөсөн хурал болоход УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар, Л.Оюун-Эрдэнэ нар 60 тэрбумын бичлэгт оролцсон этгээдүүдэд хариуцлага тооцох хэрэгтэй гэжээ. Бусад гишүүд нь Ч.Хүрэлбаатар, Л.Оюун-Эрдэнэ нарыг дэмжсэн байна.

Залгуулаад баяр наадмын үеэр МАН-ын Үүрийн дарга нар “60 тэрбумын эсрэг хөдөлгөөн” байгуулжээ. Мөн НИТХ-ын төлөөлөгчид 60 тэрбумын бичлэгийн гол хүмүүсийн нэг НИТХ-ын дарга Ц.Сандуйг огцруулахаар гарын үсэг цуглуулаад эхэлсэн байна. Түүнчлэн 60 тэрбумын бичлэгийн гол дүр болох МАН-ын дарга М.Энхболд Ерөнхийлөгчид нэр дэвшээд унасан. Тийм учраас УИХ дахь намын бүлгийнх нь гишүүд 60 тэрбумын бичлэгтэй холбогдуулан түүнтэй хариуцлага ярих ёстой гэдэг дээр санал нэгдэцгээж байгаа бололтой юм.

Учир нь МАН-ынхан М.Энхболд даргыгаа сонгуульд ялагдсанд 60 тэрбумын ярианы бичлэгээс гадна хамгийн том нөлөө үзүүлсэн нь Ж.Эрдэнэбатын тэргүүлсэн Мэргэжлийн Засгийн газар гэж үзэцгээж байна. Засгийн газар бүтэн жил ажиллахдаа танхимаа бүрдүүлэхээсээ эхлээд мордохын хазгай гэгч болсон. Шуудхан хэлэхэд, МАН-ын дарга М.Энхболдын тэргүүлдэг Хотын фракци, Уяачдын холбооныхон энэ Засгийн газрын дийлэнхийг бүрдүүлсэн. Томилгоонууд тийм ч оновчтой байж чадаагүй. Ингэж бүрдсэн Засгийн газар өнгөрсөн нэг жилийн хугацаанд МАН-ын сонгуулийн амлалтыг нам унагасан. Хэдийгээр хүүхдийн мөнгө, тэтгэвэртэй холбоотой гэнэтийн арга хэмжээг сонгуулийн дахин санал хураалтын өмнө бодитойгоор авсан ч энэ нь популист шинжтэй үйлдэл болсныг ажиглагчид, судлаачид хэлж байна.

Хамгийн сүүлийн үеийн мэдээллээр МАН-ын УИХ дахь бүлгийн гишүүд зүгээр ч нэг наадаагүй байна. Наадамчдын гал хавиар гишүүд цуглаж, зөвлөлдөөд хамгийн түрүүнд Засгийн газрыг огцруулж, сонгуулийн хариуцлага тооцох нь зүйтэй хэмээн тохирцгоожээ.

Түүнчлэн МАН дахин санал хураалтын үеэр 173 тэрбум орчим төгрөгийг бэлнээр тараасан гэх ноцтой мэдээлэл байна. Аймаг тус бүрт тэрбум, дүүрэг бүрт 5-7 тэрбум төгрөг хуваарилсан. Энэхүү 173 тэрбум төгрөгийг өмнөх алдарт 60 тэрбумын бичлэгт гардаг аргаараа, мөн концессын гэрээ, Эрдэнэс Тавантолгойн нүүрснээс босгосон байх магадлалтайг эх сурвалжууд, намынхан нь ч хэлж байна. Хэрвээ энэ мэдээлэл үнэн бол дээрх 60 тэрбумын асуудлын “учрыг олох” үед хамт яригдах учиртай юм.

Энэ мэтээр МАН-ынхан Засгийн газар, 60 тэрбумын бичлэгт оролцсон албан тушаалтнууд, явсаар намын даргатайгаа ч сонгуулийн ялагдлын хариуцлага ярих нь нэгэнт тодорхой боллоо. Тэр байтугай М.Энхболдын дараа МАН-ын дарга, дараагийн Засгийн газрын тэргүүн, Ерөнхий сайд хэн байх вэ гэдгийг ч яриад эхэлсэн байна. Шадар сайд У.Хүрэлсүх, УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар нарын хэн нэгийг дээрх албанд тохоохоор журмын нөхөд нь яриад эхэлсэн байна. Хэрэв МАН-ын дарга солигдвол ялсан намын дарга Ерөнхий сайд болдог жишиг эргэн ирэх гэнэ. Түүнчлэн дэд сайдуудыг цомхотгох тухай ч ярьж байгаа ажээ. Ийн ирэх өдрүүдэд МАН дотор маш халуун улс төр, өөрчлөлт өрнөж мэдэхээр байна.

**Хоёр. АН**

Үнэндээ АН-ын хувьд 2017 оны сонгуулиас хойш хар дарсан зүүд шиг л байсан. Сүүлдээ нам дотроо байн байн сонгуульдсаар Ерөнхийлөгчид нэр дэвшигчээ ч тэр маягаараа тодруулсан.

Тархай бутархай болоод байсан АН-ынхан Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш ямар нэг хэмжээгээр ойртож эхэлсэн. Анхны санал хураалтаар Х.Баттулга нэгээр гарсны дараа АН улам ойртсон. Х.Баттулга Монгол Улсын Ерөнхийлөгч болсны дараа АН-ын нэгдэл нягтрал маш хурдацтай явагдаж эхлэв.

Ерөнхийлөгч Х.Баттулга анхны зарлигаараа УИХ-ын дарга асан З.Энхболдыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар томилов. Ингээд харахаар энэ баг баргийн цохилтыг даахаар хүчтэй баг болж ирж байгаа юм.

Нөгөө талаар Ерөнхийлөгч Х.Баттулгын амлалтаа хэрхэн биелүүлэхийг ард түмэн харж байна. Түүнд хоёр том амлалт бий. Эхнийх нь 60 тэрбумын бичлэгийн асуудлыг нэг тийш болгох юм. Энэ тал дээр Ерөнхийлөгч Х.Баттулга МАН-ын гишүүдтэй ч хамтарч ажиллах боломжтой болж байна. Нөгөөх нь иргэдийн өрийг төлөх амлалт юм. Зайлшгүй Засгийн газартай хамтран шийдэх энэ амлалтыг биелүүлэхэд мөн л хэн гэдэг Ерөнхий сайд байх вэ гэдэг чухал юм.

Ерөнхийдөө Х.Баттулгын энэ хоёр амлалтыг ард түмэн ихээхэн анхаарч байгааг ажиглагчид, судлаачид хэлж байна.

# УЛС ТӨР

Н.БАТЗАЯА



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# ТҮЙМРИЙН АСУУДЛААР УЛСЫН ОНЦГОЙ КОМИСС ХУРАЛДАВ

Улсын баяр наадмын өдрүүдэд гарсан түймрийн улмаас Онцгой байдлын газрын албан хаагчид өдөр шөнөгүй ажиллаж буй. Энэ сарын 16-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 145 удаагийн ой, хээрийн гал түймэр гарч 38821.3 га ой, 27687 га хээр, нийт 66508.3 га талбай түймэрт өртжээ. Тодруулбал, нийслэлд 17, Архангай, Баян-Өлгий, Булган, Дорнод, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 56 сумдад 128, Улсын хэмжээнд нийт 145 удаагийн ой, хээрийн гал түймэр гарсан талаар Онцгой байдлын газраас мэдээлсэн билээ. Дээрх түймрийг унтраахаар Онцгой байдлын алба хаагчид бүрэн бүрэлдэхүүнээрээ шуурхай ажиллаж байгаа хэдий ч зарим техник, технологи дутагдалтай байгаа аж. Мөн түймэртэй холбогдуулан иргэд өөрсдийн санаачилгаар хоол хүнс, ус болон бээлий, хандив зэргийг цуглуулан гал сөнөөгчдөд өгсөн билээ. Харин албаныхны зүгээс зориулалтын нисдэг тэргийн тусламжтайгаар ус цацвал түймрийг хурдан хугацаанд унтраах боломжтой хэмээн үзэж байгаа аж. Тэгвэл түймрийн асуудлаар Улсын онцгой комисс өчигдөр хуралдлаа. Хуралдаанд Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх тэргүүтэй хүмүүс оролцов. Хуралдааны үеэр Монгол Улсын Шадар сайд үүрэг өгвөл Батлан хамгаалахын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яамны харьяа байгууллагуудын ажилтан, албан хаагчид түймэрт явахад бэлэн байна хэмээн мэдэгдсэн юм. Мөн Зам, тээврийн хөгжлийн яам нэр бүхий хоёр аж ахуйн нэгжийн онгоцыг ашиглах талаар тохиролцоонд хүрчээ. Эдгээр онгоц нэг удаагийн нислэгээр 1-2 тонн ус тээвэрлэн түймрийн голомтод цацах боломжтой гэнэ. Мөн хуралдааны үеэр холбогдох мэргэжилтнүүд түймрийн 70 орчим хувь нь хүний санамсар болгоомжгүй үйлдлээс гарсан бөгөөд цагдаагийн байгууллага эзэн холбогдогч нь тодорхой болсон дөрвөн хэргийг шалгаж эхэлсэн талаар мэдээллээ.

...Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгч хамгийн эхний ажлаа өөрийн төрсөн нутаг Баянхонгороос эхлүүлсэн билээ. Тэгвэл тэрбээр Төв аймгийн Батсүмбэр суманд асч байгаа түймрийн голомтод өөрийн биеэр очиж ажиллалаа. Түүнийг дагалдан 20 гаруй холбогдох албаны хүмүүс дагалдан явжээ...

### Ерөнхийлөгч Батсүмбэр суманд ажиллалаа

Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгч хамгийн эхний ажлаа өөрийн төрсөн нутаг Баянхонгороос эхлүүлсэн билээ. Тэгвэл тэрбээр Төв аймгийн Батсүмбэр суманд асч байгаа түймрийн голомтод өөрийн биеэр очиж ажиллалаа. Түүнийг дагалдан 20 гаруй холбогдох албаны хүмүүс дагалдан явжээ. Энэ үеэр холбогдох албаныхан "Уул уурхай байхгүй учраас хүнд даацын машин байхгүй. аж ахуйн нэгжээс хоёр, гурван машин авч ашиглаж байна. манай улсад он гарсаар 22 түймэр асч байна. Түүнээс нэгийг нь цурманд орууллаа. Мөн гурван газар машин техник очих боломжгүй. Бусад газарт Онцгой байдлын болон орон нутгийн иргэд ажиллаж байна. Өнөөдөр манай хэсэг рүү Өвөрхангай, Архангай, Өмнөговь аймгаас 60 хүн ирж яваа" хэмээв. Харин Ерөнхийлөгч Х.Баттулга ирэх хүмүүсээ нэгдсэн зохион байгуулалтад оруулж ажиллахыг үүрэг болголоо.

### Ерөнхий сайд түймрийн голомтод ажиллаж, гал сөнөөгчидтэй уулзлаа

Түймэр 22 цэгт асч байгаа учраас цааш тархах магадлал өндөр гэнэ. Мөн ойрын өдрүүдэдхэтхалж,хуурайшилт үүссэн нь түймрийн голомтыг газар авахад хүргээд байгаа аж. Улсын хэмжээнд гарсан түймэртэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат энэ сарын 15-нд шуурхай хуралдаан зарлан түймрийн нөхцөл байдлыг хэлэлцсэний дараа Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгонд гарч буй түймрийн голомтод ажиллав. Тэрбээр Онцгой байдлын албан хаагчдад хэрэгцээтэй байгаа хүнс, хувцас зэргийг хүлээлгэн өгсөн байна.

### Төв аймаг дахь түймэр 15 км газарт тархжээ

Баяр наадмын өдрүүдэд улсын хэмжээнд ой хээрийн түймрийн дэгдэлт газар авч ойн түймэр ассаар байгаа билээ. Тэгвэл энэ сарын 16-нд Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ тэргүүтэй албаны удирдлагууд Төв аймгийн Батсүбэр суманд асч буй гал түймрийн байдалтай газар дээр нь танилцаад иржээ. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат энэ сарын 15-нд шуурхай хуралдаан зарлаж, түймрийн тархалтын талаар мэдээлэл сонсон холбогдох албаныханд үүрэг өгсөн юм. Төв аймгийн Батсүмбэр суманд гарсан ойн түймрийн 16 голомтод Онцгой байдлын албанаас 700 гаруй алба хаагч, 30 автомашин, техник хэрэгсэлтэйгээр ажиллаж байгаа гэнэ. Төв аймгийн Батсүмбэр сумаас зүүн хойш 35 км-ын зайд их хэмжээний ой хээрийн түймэр долдугаар сарын 9-ний өдрөөс эхлэн тасралтгүй асаж байгаа ажээ. Замын бартаа саад ихтэй уулархаг газар учраас Онцгой байдлын гал сөнөөгчид очиход тун хүндрэлтэй гэнэ. Нийт 15 км газар нутгийг хамраад буй уг түймрийг гал сөнөөгчид цурманд нь оруулаад байгаач газрын хөрс хэт хуурайшилттай учир түймэр дахин дэгдэх магадлал өндөр байгааг хэлж байлаа. Батлан хамгаалахын сайдын ажлын бүрэлдэхүүнд Батлан хамгаалах яамны стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал Д.Сайханбаяр, ЗХЖШ-ын Ар талын хангалт үйлчилгээний газрын дарга, Бригадын генерал Эрдэнэдалай нар газар орон, цагийн байдалтай танилцан хуурай хүнс, ус гутал хувцсыг онцгой байдлын албаныханд өгөв.


# ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017 оны 07 дугаар сарын 17
**Тендер шалгаруулалтын нэр:** г-Налайх дүүргийн Хангамж үйлчилгээний төвд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх
**Тендер шалгаруулалтын дугаар:** г-НДХААА-2017/Б-13

Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба эрх бүхий тендерт оролцогчдоос г-Налайх дүүргийн Хангамж үйлчилгээний төвд хүнсний бүтээгдэхүүн–ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50'000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

**Төлбөрийг Төрийн сан банк 100200455009 тоот дансанд тушаана.**

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн буюу 2015, 2016 оны аль нэг жилд тухайн оролцож буй багцын дүнгийн 50 хувиас багагүй байна.

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тухайн оролцож буй багцын дүнгийн 30 хувиас багагүй байх шаардлагатай.

**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 2 жилийн буюу 2015, 2016 оны санхүүгийн тайлан.

**Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Тухайн оролцож буй багцын дүнгийн 30 хувиас багагүй байх.

**Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:** "Шаардлагагүй"

Тендерийн хамт Багц.1- 1'000'000, Багц.2-780'000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 08 дугаар сарын 21-ны өдрийн 10 цаг 40 минутад нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: "Үгүй"**
**Дотоодны давуу эрх тооцох эсэх: "Үгүй"**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Хуульчдын гудамж, Худалдан авах ажиллагааны алба. Утас:7023-2788**


МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

## Ерөнхий сайд ногоон бүсийн аялал зугаалгыг түр хугацаагаар хориглох үүрэг өглөө



Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат орой түймрийн тархалтын мэдээлэл сонсон холбогдох албаныханд үүрэг өгчээ. Тухайлбал, Байгаль орчны сайдад ногоон бүст иргэдийн хийх аялал зугаалгыг түр хугацаагаар хориглох, уг шийдвэрийн хэрэгжилтэд тавих хяналтыг чангатгаж, эргүүл, хамгаалалтын ажилтны тоог нэмэгдүүлж ажиллахыг үүрэг болголоо. Мөн ОБЕГ-ын удирдлагад, хүн, хүчээ зөв хуваарилан эхний ээлжид түймрийн тархалтыг яаралтай тогтоон барих, шаардлагатай тусламж, мэдээллийн талаар Ерөнхий сайдад тухай бүрт нь илтгэж, холбогдох дэмжлэг авч ажлаа шуурхай зохион байгуулахыг үүрэг болгов. Харин нөхцөл байдлыг үнэлэж, ОБЕГ-аас дэмжлэг хүсвэл зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнээс дайчлах, туулах чадвар сайтай техник хэрэгслээр туслах явдалд бэлэн байдлыг хангахыг Батлан хамгаалахын сайд болон ЗХЖШБ-ын даргад үүрэг болгосон бол Ус, цаг уур орчны шинжилгээний газрын даргад үүрэг болгожээ. Мөн Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын зүгээс түймрийн тархалтад санаа тавьж, сайн дураараа нэгдэж байгаа иргэдийн эх оронч санаачилгад талархаж буйгаа албан ёсоор илэрхийлсэн юм. Гэхдээ ой хээрийн түймэр унтраах бол тусгай хувцас хэрэглэл, тоног төхөөрөмж бүхий тусгай бэлтгэгдсэн хүмүүсийн хийдэг нэн хариуцлагатай ажил учраас иргэд сайн дураараа явах нь өөрийнхөө амь насыг эрсдэлд оруулахаас гадна тэнд ажиллаж байгаа мэргэжлийн хүмүүсийн ажилд хүндрэл учруулж болзошгүй гэдгийг онцгойлон дурьдсан байна.

## ХЗДХ-ийн салбарынхан нэг өдрийн цалингаа хандивлана



Улсын хэмжээнд ой хээрийн түймрийн тархалт онц аюултай хэмжээнд хүрсэнтэй холбогдуулан өнөөдөр ХЗДХ-ийн сайд шуурхай хуралдаан зохион байгууллаа. Энэ үеэр ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт ЦЕГ, ХХЕГ, ШШГЕГ, ХСИС-ийн удирдлагуудад ой хээрийн түймэртэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэд хэдэн үүрэг чиглэл өглөө. Тухайлбал цагдаа, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ашиглагддаг тусгай зориулалтын туулах чадвар сайтай КАМАЗ, УРАЛ, ЗИЛ 131 маркийн 21 машин механизм, техник хэрэгслээр түймэр унтраах ажилд шуурхай дэмжлэг үзүүлэхээр тогтсон байна. Мөн ХЗДХ-ийн салбарын 30 мянган ажилтан албан хаагч эх орноо гал түймрийн аюулаас аврах үйлсэд зориулж бүтэн нэг өдрийн цалингаа хандивлахаар болжээ. Түүнчлэн ХЗДХ-ийн салбарын үйлдвэрийн газрууд түймэр унтраах ажилд оролцож байгаа хүмүүст нэн шаардлагатай 10000 ширхэг брезентен бээлийг яаралтай үйлдвэрлэж нийлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Тэрчлэн Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгээс гал түймэртэй тэмцэж буй алба хаагчид болон иргэдийг түлэгдэж угаартах, бэртэж гэмтэх эрсдлээс сэргийлэх, эрүүл мэндийн яаралтай тусламж үзүүлэх үүднээс Эмнэлгийн 5 шуурхай бүлэг газар дээр нь томилон ажиллуулахаар илгээлээ. ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт нийт нутгаар зуншлага гандуу болж, хуурайшилтын зэрэг нэмэгдэж байгаатай холбогдуулан гал түймрийн болзошгүй эрсдлээс сэргийлэх үүднээс улсын хэмжээнд цагдаа болон байгаль орчны байцаагчдын хамтарсан байнгын хөдөлгөөнт эргүүл ажиллуулах, хилийн зурваст зорчих, аялал жуулчлал хийхийг түр хугацаанд хязгаарлах, түймэр тавьсан этгээдүүдийг олж илрүүлэн хуулийн дагуу хатуу хариуцлага хүлээлгэх ажилд онцгой анхаарал хандуулахыг холбогдох албаны хүмүүст үүрэг болгосон байна.

# ФОТО СУРВАЛЖЛАГА

МОНГОЛ НААДАМ-2017

# Дэлхийд ганцхан монгол наадам дэлгэр сайхан боллоо



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Э.ТУУЛ

Үндэсний тусгаар тогтнол, эрх чөлөө, түүх, эх хэл, соёл уламжлалаа нандигнах их үйлсийг үеийн үед бүтээх монгол наадам өргөн дэлгэр болж өндөрлөлөө. Дэлхийд ганцхан Монгол наадам энэ цагийг гэрчилж, өмнөх түүхийг бататгаж, ирээдүйг гэрэлтүүлэх түүчээ нь юм. Энэ л өдөр эх орны минь өнцөг булан бүрт эцэг өвгөдийн үеэс уламжлуулан ирсэн их түүх, соёлын гайхамшгийг наадамчин олон маань нүүрэндээ мишээл тодруулан ёс жудагтайгаар тэмдэглэн өнгөрүүлдэг билээ. Тулгар төр байгуулагдсаны 2226 , Их Монгол Улс байгуулагдсаны 811, Ардын хувьсгалын 96 жилийн ойн Үндэсний их баяр наадмыг Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга нээж үг хэллээ. Тэрбээр “Монгол түмний их баяр Монгол наадмын гэгээн өдрийн халуун мэндийг наадамчин түмэндээ дэвшүүлье. Монголынхоо нэрийг өндөрт өргөж яваа хүн бүрийн халуун сэтгэл, хөдөлмөр зүтгэл, өөрөө өөрсдөө эзэн байх их ухаан дээр эх орон минь өөдлөн дэвжиж явна. Тусгаар тогтнолын багана туг сүлд минь цэх байна.

Хөдөлмөрч, хичээнгүй Монгол ялж, хөгжил дэвшлийн их замд тэмүүлж байна. Монгол хэмээх нэгэн нэрийг ертөнцийн чихнээ дуурсгаж буй Монгол наадам маань бидний нэгэн чухал өв соёл билээ. Төрт ёсны их уламжлал, түүх соёлын гайхамшиг, түмэн олны сэтгэлийн цэнгэл хосолсон Үндэсний их баяр наадам маань дэлгэр зуны сайхан цагт ийнхүү эхэлж байна. Их түүх, хэл соёлоороо бахархан омогшдог Монгол хүн бүрийн сэтгэлд нар гийсэн наадмын сайхан өдөр зон олны минь сэтгэл тэнүүн, цог золбоо дүүрэн морь нь хурдан, бөх нь хүчтэй, харваач нь мэргэн байг. Дэлхийд ганцхан Монгол наадам ийнхүү эхэлж байгааг даяар олноо дуурсган зарлаж байна. Сайхан наадацгаагаарай. Туурга тусгаар улс орон минь хөгжин бадраг. Түмэн олон минь амар амгалан байг ээ” хэмээлээ. Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгч баяр наадмыг нээж үг хэлсний дараа төрийн есөн хөлт цагаан тугандаа мөргөж, хүндэтгэл үзүүлсэн юм. Баяр наадмын нээлтийн ажиллагааг ёслол төгөлдөр болж, хүчит 512 бөхийн барилдааны нэгийн даваа эхэллээ. Баяр наадмын эхний өдөр аймаг цэргийн арслан 99, аймаг цэргийн заан 19, аймаг цэргийн харцага 23, начин 46, нийт аймаг, цэргийн цолтой 170 бөх уран мэхийг уралдуулан барилдаанаа эхлүүлсэн юм. Энэ жилийн үндэсний их баяр наадамд дархан аварга нэг, улсын аварга дөрөв, улсын арслан найм, улсын гарьд зургаа, улсын заан ес, харцага 23, начин 44 нийт улсын цолтой 95 бөх зодоглож нийт 512 хүчит бөх уран мэхийг уралдуулан барилдсанаас Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын харьяат, улсын харцага Цэдэвийн Содномдорж түрүүлж, Улсын арслан цол, Увс аймгийн Улаангом сумын харьяат, улсын харцага Өлзийтогтохын Бат-Орших үзүүрлэн, Улсын гарьд цол хүртэх болзол хангав. Мөн энэ жилийн үндэсний их баяр наадмаар урианхай сурын харваанд 180 гаруй, буриад сурын харваанд 160 гаруй, халх сурын харваанд 170 гаруй, үндэсний сурвын харваанд 540 харваач нийтдээ 1100 гаруй харваач цэц мэргэнээ сорьсон юм. Харин хурдан морьдыбн уралдаанд энэ жил эрлийз адуу уралдуулахгүй гэсэн шийдвэрийг Шадар сайд гаргаснаар зөвхөн монгол морьд уралдаж, хавтай сайхан наадлаа. Ийнхүү

Тулгар төрийн 2226 жил, Их Монгол Улсын 811 жил, Ардын хувьсгалын 96 жилийн ойн их баяр наадам ёслол төгөлдөр болж, өндөрлөлөө. Хүчит бөхийн барилдаанд түрүүлж, үзүүрлэсэн бөхчүүдэд цол тэмдэг гардуулах зарлигийг Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга гаргаж, цол тэмдгийг гардуулсны дараа баяр наадмыг хааж үг хэллээ. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга “Тулгар төрийн 2226 жил, Их Монгол Улсын 811 жил, Ардын хувьсгалын 96 жилийн ойн их баяр наадам ургах нарнаас шингэх наран хүртэлх уудам их газарт ёслол төгөлдөр сайхан болж, монгол хүн бүрийн сэтгэлийн галыг бадраан өндөрлөж байна. Эр бяртай бөхчүүд маань уран хурц мэхийг уралдуулан барилдаж, ид хаваа гайхуулцгаалаа. Уяачийн эрдэм төгс, хүүхдүүдийн золбоо төгөлдөр байж, хүлэг морьд маань иртэй сайхан уралдлаа. Эрхийдээ эрчтэй харваачид маань цэц мэргэнээ сорилоо. Монголчууд бид нэгдэж, нягтарсан цагтаа ялан дийлж, хөгжин бадарч явдаг агуу түүхтэй ард түмэн. Тусгаар тогтнол, эрх чөлөөгөө хайрлан хамгаалж, эвийн хүч, эрдэм мэдлэгийг эрхэмлэн дээдэлж, шударга ёс, үүрэг хариуцлагыг ухамсарлан улам илүү хичээцгээе. Хүчирхэг Монголыг цогцлоохын төлөө хүн бүр чадахын хэрээр зүтгэж, хөдөлмөр зүтгэлээ өрх гэрийнхээ болоод улс орныхоо ирээдүйн сайн сайхны төлөө зориулж,хамтын хүчээр амжилтын төлөө зүтгэцгээе. Монгол хүн бүр эрүүл ухаан, саруул эрдэм, төгс хийморь, золботой эх орон маань цэцэглэн хөгжихийн ерөөл өргөж, үндэсний баяр наадам маань өндөрлөж байгааг уламжилъя. Хөх Монгол мандан бадраг” хэмээн ерөөлийн үгээр энэ жилийн наадмыг өндөрлүүллээ.















ХҮМҮҮС

# Ч.ТҮМЭНБАЯР: УЛСЫН НААД



Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

**-Их сунгаа мөн ч сайхан болж байна шүү. Энэ удаад 60 гаруй азарга гараанаас мордлоо. Танай галын азаргууд өнгө зүс сайтай, цээжинд давхисаар байна. Унаач хүү их туршлагатай бололтой. Ингэхэд та хэдэн настайгаасаа хурдны морь унав?**

-Би дөрвөн настайдаа аавынхаа сайвар зүсмийн морийг зайдан унаж сурсан. Хөл дөрөөнд хүрэхгүй байсан учраас зайдан унасан хэрэг. Харин морь маань номхон байсан эсэхийг эдүгээ санадаггүй. Ямартай ч нялх ногоо цухуйчихсан байсан гэхээр зургадугаар сарын эхээр юм уу даа. Тэгсэн манайх гүүгээ барих юм боллоо. Адуу урагшаа, голын зах руу бэлчихсэн тул аав маань намайг мордуулан адуу хураагаад ир гээд явууллаа. Тэгтэл морь маань хазаар дараад л өөр тийш хадуураад давхичихдаг байгаа. Энэ тухай ээж маань "Эхлээд цагаан малгай, дараа нь миний хүү хийсчихэж билээ" гэж ярьдаг байж билээ. Ингэж л би морины нуруун дээр гарсан түүхтэй. Түүнээс хойш айлын том хүүгийн хувьд аавдаа нэмэр болж, их сургуулийн оюутан болтлоо морины нуруунаас буугаагүй гэж хэлж болно. Долоон нас хүрээд л хурдны морь унасан. Бие жижиг учраас 16 нас хүртлээ хурдны морь унасан. Адуунд гүжирмэг л хүү явлаа.

**-Анх удаагаа уралдааны замд давхих хэцүү юу?**

-Хэцүү. Дөнгөж морь унаж сурч байгааг хэлэх үү, туршлага муутайг хэлэх үү. Наадамд уралдахаас өмнө хэд хэдэн том давааг давах хэрэгтэй болдог. Тодруулж хэлбэл, сунгаанууд. Анхны тохиолдолд морио давхиулах нь бүү хэл өөрөө мориноосоо унахгүй ирвэл дээдийн заяа шүү дээ. Мориныхоо дэлнээс тас зуурчихсан, нүд нь тас аниастай явж байгаа юм чинь. Амьсгаа ч авч чадахгүй, их хэцүү. Иймэрхүү маягаар эхний сунгааны ард гарах жишээтэй. Хоёр дахь дээр арай дээр. Гурав дахь буюу их сунгааны үеэр хэдийнэ туршлагатай болсон байдаг. Монгол хүүхдийн цусанд нь байх чадвар юм л даа.

**-Та унаач хүүг мордохын өмнө захиас даалгавар өгч байгаа харагдсан?**

-Унаач хүүхдээс их зүйл шалтгаалдаг. Намайг уралдааны замд гарах тоолонд аав минь үг сургаалиа хайрлаж, захиас даалгавраа өгдөг байлаа.

**-Гүжирмэг хүү байсан гэхээр эмнэг даага гаргаадаггүй нэгэн байжээ?**

-Тэгж онгирч болохгүй л дээ. Гэхдээ өөрийнхөө адуун сүрэгт эзэн нь л явлаа. Тэр үед зуны даалгаварт 2-3 даага сурга гээд заачихсан байдаг байлаа. Зарим хүүхэд 10 гаруй даага сургаж, сургуулийн эмнэг сургалтын аварга болох жишээний.

**-Өнөөдрийн их сунгаа таны хүүхэд насыг өөрийн эрхгүй бодогдуулж байна уу?**

-Тэгэлгүй яах вэ. Анх удаа хурдны морь унаж байгаа хүүхдэд бол их том даваа байдаг юм. Зарим тохиолдолд юун уралдах, мориноосоо уначихгүй бол дээдийн заяа. Мориныхоо дэлнээс тас зуурчихсан. Нүд тас аниастай. Амьсгаа ч авч чадахгүй болно шүү дээ. Иймэрхүү маягтай 14-15 км давхисны эцэст сая ухаан орж, морио ташуурдахтай болно. Харин дараагийн насанд уралдахдаа хэдийнэ туршлагатай болчихсон байдаг. Аав маань аль болох захалж давхи, байнга эргэж харж бай гэдэгсэн. Би сая унаач хүүд аавынхаа захиас даалгаврыг л хэллээ. Бас машины хатуурсан зам дээгүүр хамаагүй битгий давхиарай гэлээ. Цаг үргэлж машин давхисаар зам нь хатуурсан байдаг тул морины таханд аюултай байдаг юм.

**-Та аавынхаа үргэлжлэл болж хурдны морь уях болж, Харин хүү тань таны үргэлжлэл болж бас хурдан сайхан хүлгүүдийг уяан дээрээ сойсон харагдана. Таны хувьд морь уяж байгаа тань сонин байна. Учир нь та олон жил ширээний ардаас өндийгөөгүй хүн шүү дээ?**

-Би чинь малч удмын хүн. Дөрвөн настайгаасаа л аавыгаа дагаж, адууны тоосонд дарагдаж хүн болсон. Дунд сургууль төгстлөө аавынхаа уясан морийг унаж, аймаг, сум, багийн наадамд уралддаг байсан бол сүүлдээ аавтайгаа хамтарч морьдоо уядаг болсон. Эцэг минь нутаг усандаа нэртэй уяач явсны хувьд хүүд нь уяачийн эрдэм байлгүй яав гэж. Манайх зарим жил нас болгонд морьд уяна. Заримдаа гурав, зургаан насны морь уяна. Тэр бүхэнд тооцоотой хандана. Уяхдаа заримыг нь тавина, заримыг нь бригадад, суманд уралдуулна. Миний уясан морьд эхэндээ дундуур давхидаг байснаа сүүлдээ айргийн тавд л ирдэг болсон. Гурван жил дараалан уяхад хүн, морьгүй цэгцэрчихдэг юм билээ. Тэр үед хурдны морийг эмээлтэй унахгүй. Дандаа зайдан, хөл нүцгэн унана. Өргөн гол гатална. Давхиан дундаа л гатална шүү дээ. Зарим хүүхэд голд унаж байгаа л харагддагсан. Миний хувьд голд унаж байсангүй. Аавынхаа захиснаар гол руу орохын өмнө амыг нь татаж байгаад цогиулаад л гарах учиртай. Манай аавын захиасаар, хурдны морийг 15-20 хоногийн дотор багтаж уяа сойлгыг нь тааруулах учиртай. Хурдны морь уяж байгаа тохиолдолд есөн төрлийн хөлс гаргах учиртай. Тэр хөлсийг маш сайн гаргасан тохиолдолд уяа авсан гэж дүгнэж болно гэдэг байж билээ. Эхлээд шавар хөлс, хамгийн сүүлд нь сувдан хөлсийг гаргах ёстой. Энэ нь ямар ч шаваргүй биеэс гарах чийгийг л хэлж буй хэрэг.

**-Наадам наадмаас сумын наадам хамгийн гоё, тийм үү?**

-Надад бол бригад, өнөө цагийнхаар багийн наадам хамгийн гоё нь. Би бригадын наадамд олон удаа түрүүлж, тэр тоолонгоор ижийдээ таван литрийн бидонтой ирж байсан даа. Бригадын наадамд түрүүлэх, эсвэл айргийн тавд багтвал таван литрийн бидон, дугуй булантай цай, нэг метр цуу янбуу өгдөг байлаа. Бай шагнал нь тэр. Сумын наадамд бригадуудаас цугласан тухайн орон нутгийн хурдан хүлгүүд л уралддаг. Өөр хил залгаа сумдаас ч ирж уралддагсан. Сумын наадмын тухайд ярих юмгүй гоё. Одоогийнх шиг хурдны морьдыг машин тэрэг дагахгүй. Морьтой улс дагаж давхин эргүүлнэ. Ер нь бол хурдны морьдыг ширүүн хөөдөггүй юм шүү дээ. Ерөнхийдөө шогшуулж, ергүүлсхийгээд км-тээ тулаад эргэдэг байлаа. Тэр үед миний мэдэхийн их насны морь 32 км-ээс эргэдэг байсан. 32 км-ын цаанаас эргэхийн тулд цаг гаруй явж байж очно. Эргээд л 20, 30 минутын дотор ороод ирнэ. Эдүгээ морины зай ойртчихсон. Их нас 28 км болчихсон, дөрвөн км татчихсан байгаа юм. Азарга 26, соёолон 22 км-ээс уралддаг байсан. Улирлаас хамаарч уралдах морьдоо хэрхэн сойхыг бүгдийг тооцоолсон байдаг. Түүгээр морьд дадлага сургууль хийдэг.

**-Танайх унаган адууны угшлаа одоо ч хадгалсаар байгаа юу?**

-Бий бий. Архангай аймгийн Цагаан давааны орчимд манай дүүгийнх нутагладаг юм. Тэдний адуун сүрэг аавын минь адгуулж ирсэн адуун сүргийн үр сад. Дүүг тусдаа гарахад нь унаган адууныхаа угшлын хоёр гүүг өмч болгон тасдаж өгсөн нь эдүгээ өсч үржин олон болсон. Дүү маань ч тэднийхээ үр төлөөс ах дүү нарынхаа хүүхдүүдэд бэлэглэдэг. Өнөөдөр надтай хамт яваа бага дүү Ч..Эрдэнэбаярын маань уяж сойсон хурдан хүлгүүд ч эцгийн минь бий болгосон адуун сүргийн үр төл.

**-Их сунгааг өнгөлсөн бор саарал азарга газар холдох тусам хүч нэмэн хурдлах нь гайхамшигтай. Удам угшил нь хаанахынх вэ. Би буруу таниагүй бол Архангай аймгийн 90 жилийн ойд түрүүлсэн хурдан хүлэг мөн үү?**

-Би аравдугаар ангиа төгссөнөөс хойш адуун сүргийн тоосонд дарагдалгүй гуч гаруй жил болсон байсан. Хүүхдүүд ч том болсон. Тэд маань адуу мал сонирхох болсон тул адуу малтай болъё гэж шийдээд Сүхбаатар аймгийн Халзан сумаас хурдан удмын азарга худалдаж авсан. Эдүгээ өсч үржээд 20 гаруй тооны адуутай болсон. Бор саарал зүсмийн азарга маань Халзан сумын Шагдарсүрэн гэж хүний адууны угшилтай. Тэднийх Халзан сумандаа хамгийн хурдтай, сайн адуутай нь. Тэндээс л гол адуугаа бүрдүүлсэн. Одоо манай адуун сүрэг Төв аймгийн Баян, Багануур хавиар нутагладаг. Бага хүү маань адгуулж малладаг юм.

**-Энэ жил хэдэн насны хэчнээн морьд уяж байна вэ?**

-Энэ жил зуншлага тааруу байгаа тул соёолон үрээ, азарга хоёроо уялаа. Амжилт гаргах болов уу л гэж найдаж байна. Харин энэ бор саарал морины тухайд Сүхбаатар аймгийн уяач Одгэрэлээс хавчиг соёолон насанд нь худалдаж авсан адуу. Бор морь маань зургаан алтан медальтай. Алтан-Овоо, Гангануурын наадамд түрүүлсэн морь. Манай адуун сүрэгт ирснээс нь хойш 2013 онд өвлийн Дүнжингаравт 16-д давхиж, зун нь Архангай аймгийн 90 жилийн ойн наадамд түрүүлж байгаад барианд орохоос 500 метрийн зайд суун долоод орсон. Морь хэр хурдлах нь эр хүний хоншоор мэдэх хэрэг гэдэг дээ. Адуунд буруу өгөх хэрэг юу байх вэ. Түүний дараа Гиннесийн номд оруулах 4000 хурдан хүлэг уралдахад дээгүүр давхисан. Хангайн бүсийн морьдтой уралдаад тавд давхисан. Тэр жилээ Төв аймгийн Алтанбулагийг бүсийн уралдаанд дөрөвт ирсэн. Түүний дараа жил 2014 оны улсын наадамд уралдаад гурав, дөрөвт явж байгаад наймаар орсон түүхтэй морь. 2015, 2016 онд хөлний гэмтэлтэй учраас уяагүй юм. Энэ жилээс өвчин нь гайгүй болсон болов уу гэж бодоод уяж эхэлж байгаа. Одоо 10 настай морь. Уг нь их хурдан морь. Уяач, эзэн хоёроос л хамаараад байгаа юм.

**-Хааяа адууны зах дээр өнжих нь таны хувьд хамгийн жаргалтай мөч биз?**

-Түүн шиг жаргалтай үе хаа байх вэ. Би чинь адуун дээрээ үе үе очно. Бор морио чухал үед өөрөө эмээллээд мордоно. Хийморио сэргээнэ ээ. Одоо хүүгийнхээ адууны угшилд л их найдаад байгаа. Энэ жил халзан морио уях гээд чадсангүй. Хүүхдүүд ажил төрөлтэй болчихоод уяач руу дөхүүлж чадсангүй л дээ. Маш хурдан морь гэж боддог. Энэ жилээс өвлийн уралдаан, ирэх жилийн наадамд бор морьтойгоо хамт сойно гэсэн төлөвлөгөөтэй байгаа

**-Хурдан морины шинж гэж байдаг. Энэ шинж чанар байгаль дэлхийн хувьсал өөрчлөлтийг дагаад өөрчлөгддөг юм байна уу. Ерөөсөө хурдан хүлэг л бол хурдан л байдаг юм байна уу?**

-Морь өөрөө байгалийн амьтан. Тиймээс шандас сайт хүлэг бол төрөхдөө л хурдан төрдөг Цаанаасаа төрмөл

## Энэтхэг, Монгол хоёр улсын харилцаанд нэгэн шинэ түүх нэмэгдэв

Б.ТОГТОХ

Бүгд найрамдах Энэтхэг улсад мэдээллийн технологи, банк санхүүгийн салбарт ажилладаг эгэл жирийн залуус гурван жилийн өмнөөс дэлхий дахиныг тойрон аялах төлөвлөгөө гаргажээ. Улмаар энэ мөрөөдлөө биелүүлэхийн тулд сүүлийн нэг жилийн хугацаанд шаргуу бэлтгэж, зургадугаар сарын 06-нд анх Ташкент хотноо газарджээ. Харин тэндээс мотоцикльтой аяллаа эхлүүлж, Тажикстан, Узбекистан, Киргизстан, Казакстан, Орос зэрэг улс орнуудыг дамжсаар энэ сарын 9-нд Монгол Улсад ирсэн юм. Тэдний мотоцикльтой эхлүүлсэн аяллын зургаа дахь орон нь Монгол Улс байсан бөгөөд нийт 9000 км замыг тэд хоёр дугуйт төмөр хүлгээр туулжээ. Тэднийг Төв аймгийн Баянчандмань сумын ойролцоо "Монголын чопперчин ахан дүүс" холбооны залуус тосч аван, улмаар Энэтхэгийн Элчин сайдын яаманд хүргэж иржээ. Энэтхэгийн ард түмний эв нэгдэл, найрамдал, хамтын ажиллагааны нэгэн шинэ жимийг нээсээр ирсэн Энэтхэг улсын иргэн Деепал Камат, Дилип Кришна Бхат, Судхар Прасад нартай энэ сарын 10-нд Монголын хэвлэл мэдээллийн байгууллагын зарим төлөөлөл уулзаж, аяллын сонин сайхнаас нь хуваалцлаа. Энэхүү үйл ажиллагааг Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Суреш Бабу болон тус Элчин сайдын яам зохион байгуулсан юм. Уулзалтыг нээж Элчин сайд Суреш Бабу хэлсэн үгэндээ Монгол орон даяар наадам эхэлж, Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслол болж буй энэ цаг үед энэтхэгчүүдийн энх тайван, сайн санаа, нөхөрлөлийн бэлгэдэл болж, мэргэжлийн мотоциклчид Энэтхэгийн ард түмний мэндчилгээг уламжлахаар ирснийг хэмээлээ. Түүнчлэн, Монгол Улсаас Энэтхэг улсад суух онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Г.Ганболд энэхүү уулзалтад оролцож, дэлгэр сайхан Монгол оронд тавтай саатаж, үндэсний их баяр наадмыг үзэж сонирхохыг урьсан юм. Тэд монголын үндэсний баяр наадмыг тааруулж ирэхийг хүссэн ч зам зуурт хоног хугацаа алдаж, төлөвлөсөн хугацаанаас хожимдох шахсан хэмээн ярьж байв. Амаргүй зам, бартаа саад, байгаль цаг уурын хүнд ширүүнийг үл тоон Монгол Улсыг зорьж ирсэн нь буруу зүйл байгаагүй гэдгийг тэд бахархан ярьж байлаа. Монголчуудын найрсаг, тусархаг зан чанарыг үнэхээр төсөөлж ч байгаагүй гэдгээ тэд хэлж байлаа. Эдгээр залуус өөрийн улс оронд үйлдвэрлэсэн үнэ хямд, элдэв тоноглолгүй атлаа ямар ч бартаат замыг туулах чадвартай "Бажаж" үйлдвэрийн мотоцикльтой аялалд гарсан бөгөөд энэхүү аялалаар дамжуулан үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээ сурталчлахыг хүссэн аж. Мөн хүн зорьж зүтгэвэл ямар ч хүнд хэцүү зүйлийн ард гарч, бас аялж болдог гэдгийг харуулахыг зорьсон гэдгээ хэлж байлаа. Залуус үргэлжлүүлэн 5000 км нэмж аялах бөгөөд, наймдугаар сарын эхээр Энэтхэг улсад очсон байх зорилго тавьжээ. Мөн энэхүү уулзалтад Монголын чопперчин ахан дүүс холбооны удирдах зөвлөлийн гишүүд оролцсон бөгөөд мотоциклийн аялалыг Энэтхэг улс руу хийх, мөн аялалд болон энгийн үед ч унахад тохиромжтой "Бажаж" үйлдвэрийн мотоциклийг эх орондоо оруулж ирэн зарах, хоёр улсын эдийн засгийн харилцааг өргөжүүлэх хүсэл сонирхолтой гэдгээ илэрхийлж, энэ ажилд дэмжлэг үзүүлэхийг Элчин сайд Суреш Бабугаас хүссэн юм. Мөн эдгээр холбооны залуус өнгөрсөн хугацаанд 6000 орчим мотоциклийн тамирчдыг угтаж авсан бол хамгийн анх удаа Ази тивийн мотоцикльчид эх оронд маань ирж байгааг дуулгасан юм.




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# ДАМД МОРЬДЫНХОО ТООСЫГ ҮЗЭХ Л МИНИЙ ЖАРГАЛ

байдаг. Гагцхүү таних нь чухал. Хурдан морийг шинжээр нь шинжиж байгаад таньдаг. Энэ бол монгол ухаан. Угшил дагадаг шинж чанар бас байна. Манай аав адууг таньж авдаг, таньж уралдуулдаг байсан. Адуун сүргээсээ энийг л энэ жил уяна гээд сонгоход л тэр нь айраг түрүү авдаг байх жишээтэй. Хөвгүүддээ ч эрдэм ухаанаасаа харамгүй өвлүүлсэн. Аавын хурдан морь таних чадварыг манай бага дүү өвлөсөн. Миний хувьд сургууль ном гээд адуунаас олон жил хол явсан ч бор морио өөрөө таньж авсан даа. Хурдан хүлэг цаанаа л нүдэнд тусах нь бий.

**-Хааяа л адуун дээрээ очиход өөрийн тань адуу ээнээ таньдаг уу?**

-Таньдаг. Үнэрээр, хоолойгоор ч таньдаг. Адуу өөрөө их ухаантай. Адуу ээнээ хүлээдэг. Ээнээ ирэхээр баярладаг сонин амьтан. Ээнийхээ хиймориг дагадаг. Морь дандаа хурдан байхгүй. Эхний хэдэн жилдээ хурдална. Янз янз л байдаг. Тэгсэн атлаа ясны хурдан адуу гэж байна. Манайд нутаг усандаа алдартай ясны хурдан хээр морь байсан. Сумын наадамд дандаа түрүүлдэг. Аав тэр морийг 22 насалсан гэж ярьж байсан санагдана. Би тэр морийг унаж, хурдан морь унаж сурч байлаа. Анх үсээ хяаргүй бүрзийсэн даага байсан гэдэг. Гэсэн ч хурдны шинжтэй учраас уясан чинь гараад ирсэн гэдэг. Аавын тэр морийг анх унаж байсан хүн эдүгээ Өндөр-Улаан сумандаа бий. Нас дээр гарсан 80 шахсан өвгөн байгаа. Тийм морь ээнээ дагаж төрдөг юм шиг байгаа юм.

**-Сүүлийн жилүүдэд уяачид эрлийз монгол морьдоороо талцах болсон. Мөн түүнчлэн хөдөөгийн хөх уяачид хэмээх болж. Энэ талаархи таны байр суурь?**

-Одоо янз янзаар нь эрлийзжүүлж байгаа нь буруу. Монгол морь монгол орчинд, монгол ахуйд уралдана. Манайхан нэг эрлийз азарганд монгол гүүнд тавих, эсвэл эрлийз гүүнд монгол азарга тавьдаг. Ингээд түүнээсээ гарсан морийг хурдан гээд байгаа юм. Тэр нь явцуурч байгаа асуудал. Үүнийг хязгаарлах хэрэгтэй байгаа юм. Үржил селекц хийгээд түүнийгээ үнэд хүргэх гэж бизнес хийж буй нөхдүүд олон л байна.

Эрлийз морьдоо ачаад 18 аймаг тойроод явж байдаг. Эрлийз морьд тэсвэр хатуужил муутай учраас санхүү нэлээд шаарддаг. Энэ жилийн наадмаар Шадар сайд У.Хүрэлсүх морин уралдааны комисст төрийн сүлдэндээ мөнхөлсөн монгол морио л уралдуулаарай, эрлийз адуу уралдуулахгүй шүү. Эрлийз морь уралдуулсан хүмүүст хариуцлага тооцно шүү гэж хэлж байна лээ. Энэ бол 21 аймаг, 300 гаруй сумын моринд хайртай, морио уралдуулах гэсэн уяач бүрийн сэтгэлд нийцсэн шийдвэр болсон.

**-Жороо морь ховордчихоо юу даа. Хос жороо морь унасан хүн тэр бүр харагдахгүй юм?**

-Би бас аавынхаа адил жороо морь сонирхдог. Жороо морьд ховордчихож. Унаган жороо гэж байна. Гэнзага цацлана гэж ярьдаг шүү дээ. Тийм сайхан жороо морь ерөөсөө харагдахгүй байна. Хурдан морь, жороо морь сайн зохицдог. Жороо морь чинь яг л Ланд крузер машин шиг зөөлөн явдалтай. Би жороо морь хааяа сураглана аа. Манай аав моринд жороо оруулдаг хүн байсан. Жороо морийг бас танина. Тэр эрдмийг нь өвлөсөн хүн манайханд одоогоор алга даа.

## Т.Бат–Эрдэнэ: Адуу бүхэн гоё харагддаг ч хурдныг олж харна гэдэг бэлгийн нүд юм

*Миний хөвгүүд адууны ойр өссөн. Одоо хажууд суугаа энэ нөхөр, Т.Бат-Эрдэнэ маань хүүхэд байхын адуунд сонирхолтой. Амралтаараа дандаа морь унадаг байсан. Бага дүү Эрдэнэбаяр маань хурдан морь уяна. Түүнийг дагаж явсаар хурдан моринд хорхойтой болсон хэрэг. Эдүгээ аавдаа зарим талаар зөвлөгөө өгөх болсон байна лээ. Т.Бат-Эрдэнэ дээрээ адуун сүргээ байлгадаг юм хэмээн хүүгээрээ бахархаж суусан. Ингээд залуу уяач Т.Бат-Эрдэнэтэй хурдан бор морины хөлсийг хусах зуур нь ярилцлаа .*

**-Бат-Эрдэнэ ээ, хурдан морийг танихад хурдны шинжээс гадна бэлгийн нүд гэж байдаг юм байна уу эсвэл?**

-Ер нь бол өвөг дээдсийн ухаан гэж хэлэх ёстой байх. Түүнээс гадна таны хэлсэнчлэн бэлгийн нүд гэж бий. Адууг харахад бүх адуу гоё харагддаг. Тэдэн дундаас шандас сайтайг нь олж харах нь чухал.

**-Шинэ залуу уяачид төрж гарч байгаа дуулддаг л юм. Гэхдээ уулзаж учирч явсангүй. Өөрийн тань эргэн тойронд моринд сэтгэл зүрхээ зориулсан залуус хэр байдаг юм байна?**

-Олон байгаа.

**-Ер нь моринд дурлахын мөн чанар нь юу юм бэ?**

-Цаанаасаа л байдаг байх. Хөдөө өссөн атлаа морь сонирхдоггүй хүн байдаг. Гэтэл хотод өссөн хэрнээ морь гэхээр суудлаасаа өндийх нэгэн ч байдаг л юм. Ер нь монгол хүний цусанд моринд дурлах шинж байдаг юм.

**-Жаргал нь юу юм бэ. Хурдан морь амьдралын тань нэгээхэн хэсэг болсон байна шүү дээ?**

-Цаг заваа зарцуулаад явж буй нь бусдад ядарч буй мэт харагдаж мэдэх ч ядраагүй амарчихсан байдаг. Өөр юу ч бодохгүй. Зөвхөн морио л бодно. Морины хажууд өнжих шиг жаргал үгүй. Адуу өөрөө их гоё амьтан л даа.

## Х. Баярбат: Монгол морио уралдуулж байгаа уяачдын хөдөлмөрийг үнэгүйдүүлж болохгүй

*Энэ эрхэм бол Төв аймгийн Баянцагаан сумын уяач. Хөдөөний цөлх эр. Гэвч түүний цээжинд монгол морио гэсэн чин сэтгэл бий. Тэрбээр сүүлийн жилүүдэд эрлийз морьдыг улсын баяр наадамд бүү хэл, аймаг сумандаа уралдуулахгүй байх тухайд өөрийн байр суурийг илэрхийлэх болсон цөөн хүний нэг.*

**-Хэдий үеэс морь уяж эхлэв?**

-Аав, ээж маань бүхий л насаараа мал дагасан улс. Би ч ялгаагүй, ухаан суусан үеэсээ өнөөг хүртэл мал дагаж, адууны дэргэд явна. Биеийн тамирын дээд сургууль төгсч, хэсэг хугацаанд хилийн чинадад амьдарсан удаатай ч адуугүйгээр амьдарч чадахгүй юм билээ. Тэгээд л эх орноо, адуугаа гэсээр ирсэн. Хүүхэд байхдаа хурдны морь унадаг байлаа. Моринд хүнддэх болсноос хойш аавдаа туслан туслах уяач болсон. Миний халтар азарга 2009 онд Төв аймгийн наадамд түрүүлсэн. Үүнд урамшаад бие даан морь уяж эхэлсэн.

**-Энэ жил танай гал хэдэн насанд хэчнээн морь уяж байна вэ?**

- Аавынх манай хоёр нийлээд зургаан насны морь уясан. Нэг насанд гэхэд гурав, дөрвөөр нь гээд нийтдээ 20 орчим морь уяж байна. Улсын наадамдаа хээр, халзан азаргаа уралдуулах төлөвлөгөөтэй байгаа. Дээр нь Түмэнбаяр ахын бор морь уралдана. Улсын наадамд уралдаж сурсан морь байгаа юм. Энэ жил уяа, уяач хоёр нь солигдоод цалгардуу байгаа байж мэднэ. Гэхдээ яах вэ, сурсан газарт нь уралдуулна. Иим гурван морио улсын наадамд сойно доо.



**-Уяач бүхэнд улсын наадамд морио уралдуулна гэдэг тэр бүр олдох хувь тохиол биш байх?**

-Тийм шүү. Алс баруун хязгаарынх бол тэр бүр ирж чадахгүй шүү дээ. Үнэхээр гоц хурдан адуутай бол ирэх л байх. Түүнээс биш айргадахааргүй адуутай бол ирэхгүй.

**-Уяач бүр л өөрийн хүлгийг түрүүлчихээсэй л гэж боддог. Гэхдээ тухайн жилийн өнгө, газрын гарцнаас хамаарч, тэр зүгийн адуу хурдтай байх болов уу гэх яриа уяачдын дунд жилийн жилд өрнөдөг. Та уяач хүний тухайд ямар бодолтой байдаг вэ?**

-Тэгэлгүй яах вэ. Хаана зуншлага сайхан эхэлж байна, тэнд адуу түрүүлж тарга тэвээрэг нь сайжирч байдаг. Гэхлээ гэхдээ шинэ ногоог гүйцэж нөхөх нь ховор. Энэ жил Хөвсгөл чиглэл, говийн аймгууд наадамд өнгөтэй байх болов уу гэж бодож байна.

**-Их сунгаанд хоёр азарга тань ямархуу байх юм?**

-Хээр азарга ерөнхийдөө хөнгөн, аятайхан л байна. Уяа сойлго нь таарсан юм болов уу даа. Халзан азарганы тухайд цалгардуухан байгааг нуугаад яах вэ. Гэхдээ болно биз дээ. Уяач бүр л морио айргадаж түрүүлнэ гэж бодож очиж байгаа. Ямартай ч, улсын наадамд тоосоо өргөнө.

**-Улсын наадамд явахын өмнөх орой унаач хүүхэд, уяач хүний хувьд догдлоостой байдаг байх?**

-Тэгэлгүй яах вэ, догдолно. Наадмын маргаашаас л дараа жилийн наадам хүртэл бүтэн жилийн турш хүлээж догдолдог юм шүү дээ. Морьдоо уяад эхлэхээр цаг хугацаа нэг мэдэхэд л өнгөрсөн байдаг юм. Уяач хүүхдүүд ч бидний адил догдлоод нойргүй хонох нь бий. Манай Баянцагаан сумын адуу нэг хэсэг улсын наадмын өнгийг тодорхойлж байлаа. Тийм цаг ирэх нь дамжиггүй.

**-Сүүлийн үед төр, засгаас анхаарч байгаа ч, эцсийн үр дүнг нь үзэж чадахгүй байгаа нэг зүйл нь эрлийз морьдын асуудал. Ер нь монголчууд морио уяж, уралдуулж сурч байна уу?**

-Энэ тал дээр нэлээд зүйл яримаар санагддаг. Эрлийз морьдыг монгол морьтой хольж уралдуулаад байгаа юм. Энэ бол олон зууны турш өвлөгдөж ирсэн монгол өв уламжлалыг эвдэж буй хэрэг. Дээр нь монгол морио уралдуулж буй монгол малчны хөдөлмөрийг үнэгүйдүүлээдзогсохгүймонгол наадмыг хэдхэн мөнгөтэй уяач луйвардаж, будлиулдаг болсоор арав гаруй жилийн нүүрийг үзлээ. Уг нь монгол морьдынхоо үүлдэр угсааг сайжруулах зорилгоор эрлийзжүүлж, дөрөвдүгээр үеэс нь уралдуулж болох зөвшөөрлийг Монголын морин спорт уяачдын холбоо өгсөн. Өөрөөр хэлбэл, эрлийз адуу гурав дахь үеэсээ уралдаж болно гэсэн үг. Харин эрлийз монголоороо хольж уралдах нь буруу. Үүнийг хуульчилаад зогсохгүй тийм тохиолдолд хариуцлага тооцдог болмоор байгаа юм. Утга учиргүй мөнгө цацаж эрлийз адууг үржүүлээд түүгээрээ бизнес хийдэг цөөн хэдэн хүний эрх ашигт тэр үйлчилж болохгүй. Үнэхээр эрлийз адуугаа уралдуулах сонирхолтой юм бол морин тойруулгын уралдаанаа зохион байгуулдаг байх хэрэгтэй. Тэр бүү хэл, хилийн чинадад улсынхаа нэрийг гаргах сонирхолтой юм бол эрх нь нээлттэй байгаа шүү дээ. Үндэсний баяр наадмаар зөвхөн монгол мориныхоо шандас шөрмөсийг сорих хэрэгтэй. Монгол адууныхаа тэсвэр хатуужлыг шалгадаг юм, энэ үеэр. Үүний цаана монгол өв соёл, монгол адууны гайхамшиг гэж бий. , Мөн бас нэг хөндвөл зохих зүйл бол уралдааны зай хэмжээ жилээс жилд алдагдаж буй явдал. Их насны морьд гэхэд дээр үед 30 км-т уралдаж байсан гэдэг. Одоо гэхэд 26 км. Зайг нь яс хэмжвэл 24 км болсон байж ч магад. Уяач хүний тангараг гэж байдаг. Уяач хүн хэзээ ч морьдынхоо насыг дарж уралдуулдаггүй. Эрлийз, монгол морьдыг уралдуулахад уяач хүний ёс жудаг гэж зүйл бий. Энэ мэтчилэн яриад байвал зөндөө юм бий.

Үүнийг байхгүй болгоё, ялгая гэвэл их амархан. Харамсалтай нь хэн ч ялгахыг хүсэхгүй байгаа юм. Баяр наадмын комисст орж буй хүмүүс нь ч ялгаж мэддэггүй. Өнгөрсөн жил Эрдэнэтийн наадамд гомдол гаргаж үзсэн. Нэмэргүй юм билээ. Сүүлдээ монгол морьдыг хүмүүс тоохоо болих шинжтэй.

**-Уяач хүний тангараг гэж бий хэмээн та саяхан онцоллоо. Энэ тухай анх удаа сонслоо?**

-Хятадууд цусаар нь уусгана гэж ярьдаг. Сүүлийн үед өвөрмонголын уяачид цэвэр цусны хятад адуугаа оруулж ирээд монгол адуутай нийлүүлэхийг чухалчлах болсон байна лээ. Нөгөөтэйгүүр, зарим нь эрлийз адууг хэт довийлгож, монгол адуу хэрэггүй мэт ярих болж. Би тэднийг өв соёлоосоо урвагч гэж боддог.

Улсын наадамд азарга эхэлж уралддаг байсан, одоо больчихсон. Морины төлөө олон жил хөдөлмөрлөсөн хүнд л гавьяа шагналыг нь олгодог баймаар. Сүүлийн үед нэр төр хөөсөн уяачид эрлийз морь уралдуулан амар хялбар замаар амжилтад хүрдэг болсныг би хувьдаа буруу зүйл гэж боддог. Бас нэг хатуу хэлэх зүйл бол хөдөөний уяачдыг илт ад үзэх болсон байна лээ. Зурагтаар хүртэл хөдөөний хөх уяач хэмээж байгаа нь бидэнд таалагдаагүй.

**-Хурдан морины тухай хууль гэж ер нь байна уу?**

-Уяачдын холбооны мөрдөх журам дотор Улсын баяр наадмын стандартыг тогтоогоод оруулсан байгаа. Харамсалтай нь үүнийгээ хэрэгжүүлдэггүй. Хэрэгжүүлэх үүрэг бүхий хүмүүс нь хэн нэг том дарга үйлчилж, түүний эрх ашигт нийцүүлж байх жишээний. Шуудхан хэлэхэд, мөнгө авдаг. Ингэж болохгүй. Уяач хүний хэдэн жилийн хөдөлмөрийг мөнгөөр хэмжиж болохгүй. Уяач хүн монгол ёс заншил, өв уламжлалаа давхар авч явдаг юм.

**-Сумандаа жинхэнэ наадам болж чадаж байна уу?**

-Сүүлийн жилүүдэд бас л алдагдах болсон. Болсон болоогүй эрлийз адуунууд уралдан түрүү магнайг нь авчихдаг. Харин говийн аймгууд сайхан наадлаг. Дэг журамтай, машин тэрэг дагуулдаггүй. Үүндээ Улаанбаатартай ойртоод ирэхээрээ л буруу юманд уриалсан, доль цохисон уяачид их байх юм.

## ДЭЛХИЙ

# ТЭД БИДНИЙ ТУХАЙ

### Associated Press: Монгол бизнесийн магнат Ерөнхийлөгчтэй боллоо

Бизнесийн магнат, жүдо бөхийн од Ерөнхийлөгчийн сонгуулийн шийдвэрлэх шатны санал хураалтад эрх баригч намын нэр дэвшигчээс илүү санал авч, ялалт байгууллаа. Саналын хуудасны ихэнхийг тоолж дууссаны дараа Ардчилсан намаас нэр дэвшигч Х.Баттулга 50.6 хувийн санал авч тэргүүлсэн бол МАН-ын нэр дэвшигч М.Энхболд 41.2 хувийн санал авлаа. 30 орчим жилийн өмнө коммунист дэглэмд цэг тавьснаас хойш ардчиллын баян бүрд болон оршин тогтносон гуравхан сая хүн амтай тус улсын улс төр дэх эрх баригчдын авлига хээл хахууль, эдийн засгийн хямралтай холбоотой зөрчилдөөн хурцадсаар байгаа. Х.Баттулга сонгуульд АНУ-ын төрийн тэргүүн Доналд Трамптай адил "Монгол нэгдүгээрт" гэх бодлогын дагуу кампанит ажилаа зохион байгуулсан. Тэр хэдий өмнө нь шүүмжилж байсан ч, БНХАУ зэрэг хөршүүдтэйгээ тэгш хамтын ажиллагаатай, эх оронч Ерөнхийлөгч байхаа амласан юм. Х.Баттулга "Ассошэйтэд пресс" агентлагт ярилцлага өгөхдөө гадаадын хөрөнгө оруулалт, технологийг улс руугаа татна гэдгээ хэлжээ. Ингэхдээ монголчууд илүү их ашиг хүртдэг болгохын төлөө тэмцэнэ гэсэн юм. Тэрбээр "Эрх баригч нам сонгуулийн сурталчилгааны үеэр хэрэв Баттулга Ерөнхийлөгч болбол гадны хөрөнгө оруулалт зогсоно гэсэн сөрөг мессэжийг сонгогчдод өгч байсан. Би гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана. Гэхдээ хамгийн чухал нь энэ харилцан ашигтай байх хэрэгтэй. Энд БНХАУ, эсвэл ОХУ өөр ямар улс байх нь хамаагүй" гэж ярьсан байна. Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалт Рио Тинто болон тус улсын Засгийн газар хоорондын маргаан, уул уурхайн бүтээгдэхүүний үнийн уналттай холбоотойгоор сүүлийн жилүүдэд буурсан. 2011 онд 17.5 хувийн дэлхийн хамгийн өсөлттэй эдийн засагтай орон байсан тус улсын эдийн засгийн өсөлт өнгөрөгч онд ердөө нэг хувьтай гарсан юм.

### Aljazeera.com: Х.Баттулга энгийн мессэжийг өгч, сонгуульд ялсан

Монголын анхны Ерөнхийлөгчийн сонгуулийн шийдвэрлэх шатны санал хураалтыг сөрөг хүчнээс нэр дэвшигч тэргүүллээ. Ардчилсаннамаас нэр дэвшигч тулааны урлагийн од тамирчин 54 настай Х.Баттулга санал тооллогын явц 87 хувьтай байхад 50.7 хувийн санал авсныг СЕХ мэдээлсэн. Дүн гарсны дараа Баттулга хэвлэлийн бага хурал хийж, энэ үеэр "Монгол яллаа" хэмээн ялалтаа зарласан байна. Мөн "Би монголчуудаа өргүй болгож, эдийн засгийн хүндрэлийг даван туулах амлалтаа биелүүлэхийн төлөө ажиллана" гэв.

Харин УИХ-д олонхийн суудал эзлэх МАН-аас нэр дэвшигч, УИХ-ын дарга М.Энхболд 41 хувийн санал авсан байна. Түүнчлэн, сонгогчдын 8.3 хувь нь хоосон хуудас уншуулжээ.



ОХУ, БНХАУ-ын дунд орших гурван сая хүн амтай өргөн уудам газар нутагтай тус улсын маш олон сонгогч улстөрчдийн сонгуулийн сурталчилгаанаас залхсандаа ямар ч тэмдэглэгээгүй хоосон хуудас уншуулсан нь энэ. Хуулийн дагуу 50-иас илүү хувийн санал авсан нь ялагч болох ёстой. Харин нэр дэвшигчдийн хэн нь ч энэ тоонд хүрээгүй тохиолдолд намууд дахин өөр хүнийг нэр дэвшүүлж, шинэ сонгууль явуулах ёстой байв. Эдүгээ шинэ Ерөнхийлөгч эдийн засгийн тогтворжуулах зорилготой Валютын сангийн хөнгөлөлттэй санхүүжилтийн хөтөлбөр хийгээд Монгол Улсын экспортын БНХАУ-аас 80 хувь хараат байдлыг багасгах зэрэг ажлуудтай нүүр тулна. 4.1 сая ам.долларын өртгөөр баригдсан Чингис хааны асар том хөшөөт цогцолборыг санхүүжүүлсэн үл хөдлөх хөрөнгийн магнат Х.Баттулга монголчуудаа өргүй болгоно гэж мөн амласан юм. "Аль Зажеера"-гийн Улаанбаатар хотод ажилласан сэтгүүлч Адриан Броуны хэлж буйгаар сөрөг хүчний нэр дэвшигчийн дээрх амлалт олон сонгогчдын санал авахад нөлөөлсөн аж. Түүнчлэн, "Х.Баттулга маш энгийн мессэжийг сонгогчдод өгснөөр яллаа. Тэр Монголыг нэгдүгээрт гэсэн платформын дагуу кампанит ажиллаа явуулж, БНХАУ-тай холбоотой асуудалд хатуу байр суурьтай байхаа амласан. Тодруулбал, тэрбээр Бээжинтэй эрх тэгш харилцаатай байхыг хүсдэг гэдгээ хэлсэн юм. Мөн яг одоо хүмүүсийн хамгийн их санаа зовниж буй ажилгүйдлийг шийдвэрлэхээ амласан. Өргөн уудам нутагтай ч, далайд гарцгүй тус улсын олон мянган иргэд ядууралд өртөж байна" хэмээн Броун мэдээлжээ.

### Nikkei.com: С.Ганбаатарыг дэмжигчид сонгуулийн түлхүүрийг атгаж байлаа

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн шийдвэрлэх шатны санал хураалт энэ сарын 7-нд явагдлаа. Сонгуулийн Ерөнхий хорооны оройн 23:30 цагийн урьдчилсан дүн мэдээгээр, зургадугаар сарын 26-нд болсон нэгдэх санал хураалтад тэргүүлсэн Ардчилсан намын нэр дэвшигч Х.Баттулга ялж, 50-иас илүү хувийн санал авах нь тодорхой болсон юм. Шийдвэрлэх шатны санал хураалтад Х.Баттулгатай, эрх баригч намын нэр дэвшигч М.Энхболд өрсөлдсөн. Өмнөх санал хураалтад Х.Баттулга 38, М.Энхболд 30 хувийн санал авсан бол маш бага хувийн зөрүүгээр МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар ялагдаж, шийдвэрлэх шатны санал хураалтад өрсөлдөх боломжгүй болсон. МАН парламентын сонгуульд үнэмлэхүй олонхи болсоныхоо дараа өнгөрөгч хоёрдугаар сард Валютын сангийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт төсвөө бүхэлд нь танах нөхцөлтэйгөөр хамрагдахаар болсон юм. Үүний улмаас татвар, тэтгэвэрт гарах насыг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Харин иргэдийн ихэнх нь хэмнэлтийн бодлогод сэтгэл дундуур байсан нь УИХ-ын дарга М.Энхболдын ялагдах шалтгаан боллоо. Эрх баригч намын хувьд шийдвэрлэх санал хураалт болохоос ердөө хэдхэн хоногийн өмнө энэ оны эхэн үеэс зогсоосон хүүхдийн тэтгэмжийг нөхөн олгож, зэсийн уурхайн 49 хувийн хувьцааг ард иргэддээ хуваарилахаа мэдэгдсэн.

Ардчилсан нам ч гэсэн гадаадад байгаа хууль бус мөнгийг буцаан авчирч, иргэдийнхээ банкны өрийг дарах амлалт өгөх зэргээр сонгуулийн өрсөлдөөн сүүлийн хэдхэн хоногт улам бүр ширүүссэн юм. Үндсэндээ өмнөх санал хураалтад С.Ганбаатарыг дэмжиж саналаа өгсөн иргэд энэ удаагийн санал хураалтыг түлхүүрийг атгаж байлаа. Гэсэн ч, МАХН сонгуулийг хүчингүй болгохыг иргэдэд уриалж байв. Нэр дэвшигчдийн хэн нь ч 50 хувийн дэмжлэг авч чадахгүй бол дахин сонгууль болох хуультай учраас тус нам дэмжигчиддээ хоосон хуудас уншуулахыг уриалж байсан хэрэг.

## 20 настай түвд оюутан өөрийгөө шатаахыг завдлаа

Энэтхэгийн хойд этгээдийн Уттар Прадеш мужийн Варанаси хотод байрлах Түвд судлалын их сургуулийн 20 настай эрэгтэй оюутан "Эрх чөлөө" хэмээн хашгирсаныхаа дараа өөрийгөө шатаахыг завджээ. Энэ явдал энэ сарын 14-нд гарсан бөгөөд оюутан хүнд гэмтсэн байна. БНХАУ-ын Засгийн газраас Түвдийн эсрэг явуулж буй бодлогыг эсэргүүцэн нэг бус удаа түвд хүмүүс өөрийгөө шатааж, тэмцэж байсан удаатай. Гэхдээ Энэтхэгт өөрийгөө шатаасан тус залуугийн үйлдэл дээрх шалтгаанаар бус гэдгийг цагдаагийнхан мэдэгджээ. Тодруулбал, оюутан шалгалтдаа унаснаас болж, амиа хорлохыг завдсан байж магадгүй хэмээн үзэж байгаа юм байна. Варанаси хотын цагдаагийн газрын хэвлэлийн төлөөлөгч Санжай Трипати "Франц пресс" агентлагт "Амиа хорлохыг завдсан шалтгаан нь одоогоор тодорхойгүй байна. Гэхдээ гэрчүүдийн хэлж буйгаар тэрбээр "эрх чөлөө" хэмээн хашгирч гүйж гарсныхаа дараа өөр рүүгээ шатахуун цацаж, гал тавьсан байгаа юм" гэж ярьжээ.

Харин их сургуулийн удирдлагууд шалгалтын дүнг залуу амиа хорлох оролдлого хийхээс яг нэг өдрийг өмнө зарласан хэмээн мэдэгдсэн байна. Тус залуу хоёр шалгалтдаа хангалтгүй дүн авсан байжээ. Нөгөөтэйгүүр, Түвдийн хүний эрхийн байгууллага "International Campaign for Tibet" залуугийг Тензин Чойинг гэгч болохыг нь тодорхойлсон байна. Одоогоор цагдаагийн алба хаагчид эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй оюутан болон түүний гэр бүлийнхнээс мэдүүлэг авахаар төлөвлөж байгаа аж. Залуу 50 хувийн түлэгдэлттэй байгаа гэнэ.

# ЦЭРГИЙН ЭРГЭЛТ ХИЙХ ОРОЛДЛОГООС ХОЙШ НЭГ ЖИЛ



Б.ДАВАА

Туркид Ерөнхийлөгч Ресеп Тайип Эрдоганы засаглалыг түлхэн унагах зорилготой төрийн эргэлт хийх оролдлогоос хойшхи нэг жилийн ой тохиож, тус улсын иргэд өргөн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлжээ. Тодруулбал, Туркийн эрх баригчид жил бүрийн долдугаар сарын 15-ны өдөр буюу цэргийн эргэлт хийх оролдлого гарсан ч, ард түмний эсэргүүцэлтэй тулгаран бүтэлгүйтсэн тэрхүү өдрийг "Ардчилал, эв нэгдэл"-ийн өдөр болсон тэмдэглэх шийдвэр гаргасан байна. Учир нь 2016 оны долдугаар сарын 15-ны цэргийн эргэлт хийх оролдлого нь өөрөө Туркийн ардчилалын түүхэн ялалт хэмээн албаныхан тодорхойлж буй аж. Харин олон улсын хэвлэлд Ерөнхийлөгч Р.Эрдоган ард түмний эв нэгдэл хийгээд өөрийн хүчийг харуулах өдөр болгон тэмдэглэхийг зорьж байна хэмээжээ.

Туркийн анхны "Ардчилал, эв нэгдэл"-ийн өдрийн баярын үйл ажиллагаа тусгай хуралдаанаар эхэлсэн байна. Энэхүү хурлыг тус улсын Ерөнхий сайд Бинали Йилдирим нээж үг хэлсэн бөгөөд тэрбээр "Түнэр харанхуй шөнө баатарлаг туйлс болсон тэрхүү өдрөөс хойш нэг жил өнгөрлөө" гэжээ. Цэргийн эргэлтээс хойшхи нэг жилийн ойн баярын үйл ажиллагаа Истанбулын Босфорын сувагт мөн зохион байгуулагджээ. Тус суваг буюу цэргийн эргэлтийн хамгийн ширүүн тэмцэл Босфорын гүүрэнд болсон гэдэг. Тэгвэл гүүр хүртэл Ерөнхийлөгч Эрдоган F16 байлдааны хөлөг онгоцоор Анкарагаас нисэж, Истанбулд хүрсэн байна. Тэнд ард түмний баярын жагсаал зохион байгуулагдсан аж. Улмаар Босфорын гүүрэнд болсон тайван жагсаалд хэдэн зуун мянган иргэдийнхээ хамт Ерөнхийлөгч Эрдоган алхсан бөгөөд оролцогчид төрийн далбаагаа намируулж, "Бид Ерөнхийлөгч Ресеп Тайип Эрдоганы цэргүүд" хэмээн хашгирч байсан аж.

Сүүлийн 15 жилийн турш Туркийн бүхий л эрх мэдлийг гартаа атгаж буй Ерөнхийлөгч Р.Эрдоганы бодлогыг эсэргүүцсэн хэсэг цэргийн алба хаагчид танк, сөнөөгч онгоц ашиглан цэргийн эргэлт хийхийг завдсан ч, бүтэлгүйтлээр төгссөн байдаг. Тухайн үед үйл ажиллагаанд оролцсон 249 цэргийн алба хаагч амь үрэгдсэн гэх мэдээлэл бий. Тэр өдөр Засгийн газрын алба хаагчид болон Ерөнхийлөгч Эрдоганыг дэмжигч иргэд гудамжинд гарч, цэргийн эргэлтийг эсэргүүцэн тэмцжээ. Үүний улмаас хэдхэн цагийн дараа цэргийн эргэлт хийх оролдлого талаар болж, манлайлагчид нь амь үрэгдсэн байна. Туркийн Засгийн газар энэхүү цэргийн эргэлтийг эдүгээ АНУ-д амьдарч буй исламын шашны номлогч Фетуллах Гюлен болон түүнийг дэмжигчид удирдсан гэж үздэг.

Мөн эл өдрийг угтан 7000 орчим төрийн болон цэрэг, цагдаагийн алба хаагчдыг хомроглон халсан байна. Цэргийн эргэлтээс хойш Туркид ойролцоогоор 5000 орчим хүн баривчлагдсан бол 100 мянга гаруй хүн ажлаасаа халагдахад хүрсэн байдаг.

Орон нутгийн "Анадолу" агентлагийн мэдээллээр, энэ удаа нийтдээ 7563 хүн халагдсан байна. Тэдний 350 нь ахмад дайчид байсан бөгөөд цэргийн цолыг нь мөн хураажээ. Түүнчлэн, 2300 цагдаагийн алба хаагч ажлаасаа чөлөөлөгджээ. Тэднийг "Террорист байгууллага болон улс орны аюулгүй байдалд хохирол учруулахуйц бүлэглэлтэй холбоотой" гэх шалтгаанаар ийнхүү хомроглон халсан тухай хэвлэлд дурьдсан байна.

## Афганистаны тамирчид Вашингтонд очжээ

АНУ-ын нийслэл Вашингтон ДС хотод зохион байгуулагдаж буй Роботын олон улсын тэмцээнд оролцохоор визийн мэдүүлэг өгсөн ч, татгалзсан хариу сонссон Афганистаны шигшээ багийн тамирчид өчигдөр АНУ-д очжээ. Зургаан эмэгтэй гишүүдээс бүрдэх тус баг Вашингтон Даллесын олон улсын нисэх онгоцны буудалд өчигдөр хүрсэн бөгөөд тэднийг АНУ-д суух Афганистаны Элчин сайдын яамныхан болон дэмжигчид нь угтан авсан байна.

Олон улсын роботын "FIRST Global Challenge" тэмцээн Вашингтонд гурван өдөр үргэлжлэх бөгөөд маргааш өндөрлөх аж. Тус тэмцээнд дэлхийн олон орны хими, технологийн чиглэлээр суралцдаг оюутнууд бүтээлээрээ өрсөлддөг байна. АНУ-ын эрх баригчид эхэндээ Ерөнхийлөгч Доналд Трампын виз олгох нөхцлийг чангатгах шийдвэртэй холбоотойгоор лалын шашинтнууд хүн амын ихэнхийг эзлэх улс орны төлөөлөгчдийг тэмцээнд оролцуулахаас татгалзсан хариу өгч байжээ. Энэ дагуу Афганистаны тамирчдыг оролцуулахаас татгалзсаны дараа олон улсын зүгээс хүчтэй шүүмжлэлд өртсөний дараа энэ сарын 12-нд виз олгох шийдвэр гаргасан байна. Тэмцээнийг зохион байгуулагчдын хэлж буйгаар исламын шашинтай Йемен, Марокко зэрэг дэлхийн 163 орны баг тамирчдад виз олгожээ.



Реклам, зар сурталчилгааны алба: 99173710



МЭДЭЭЛЭЛ

## Өрх толгойлсон эмэгтэйчүүдэд гэр бэлэглэв

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд "Зорилтот бүлэгт чиглэсэн" дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж байгаа ажээ.

Мөн орон гэргүй иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, өрх толгойлсон эмэгтэй, ажилгүй орлогогүй олон хүүхэдтэй өрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг орон гэртэй болгоход анхаарч ажиллаж байна. Энэ хүрээнд УИХ-ын гишүүн Д.Мөнхцэцэг, аймгийн Засаг дарга Г.Батсуурь, аймгийн Засаг даргын орлогч Ш.Билэггүмбэрэл, ИТХ-ын нарийн бичгийн дарга Ж.Оюунбилэг болон албаны бусад хүмүүс таван хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэйчүүдэд гэр бэлэглэжээ. Тухайлбал, өрх толгойлсон эмэгтэй С.Гандолгор, Д.Хосцэцэг, Д.Оюунцэцэг, Э.Ганболд, Я.Энхтуяа нарын таван өрхөд өргөө цагаан гэр гардуулан өгчээ.

## Пауэрлифтингийн улсын аваргаас алтан медаль хүртжээ



Пауэрлифтингийн 11 дэх удаагийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд Говьсүмбэр аймгийн уугуул, тамирчин Н.Амарбаясгалан насанд хүрэгчдийн ангилалд нэг алт, хоёр хүрэл, залуучуудын ангилалд хоёр алт, нэг мөнгө, нэг хүрэл медаль хүртсэн байна. Мөн Н.Баярбат залуучуудын ангилалд нэг хүрэл, нийт найман медаль хүртлээ. Тодруулбал, Н.Баярбат залуучуудын эрэгтэй ангилалын 74 кг-н штангтай хэвтээ шахалтын төрөлд 145 кг өргөж хүрэл медаль, Н.Амарбаясгалан насанд хүрэгчдийн эрэгтэй ангилалын 59 кг-ийн жингийн штангтай суултын төрөлд 182.5 кг өргөж алт, штангтай хэвтээ шахалтын төрөлд 132.5 кг өргөж хүрэл, нийлбэр дүнгээр 460 кг өргөж хүрэл медалийн эзэн болжээ. Мөн залуучуудын эрэгтэй ангилалын 59 кг-ийн жинд, штангтай хэвтээ шахалтын төрөлд 140 кг өргөж алт, штангтай суултын төрөлд 180 кг өргөж мөнгө, газраас штанг татах төрөлд 160 кг газраас татаж хүрэл, нийлбэр дүнгээр 480 кг өргөж алтан медаль тус тус хүртсэн байна.

## "Мак нээлттэй өдөрлөг" боллоо



Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар, Монголын алт компани, Хөх цавын цементийн үйлдвэр хамтран "Мак нээлттэй өдөрлөг"-ийг зохион байгууллаа. Өдөрлөгт тус аймгийн Засаг дарга Г.Батсуурь, "МАК Цемент" компанийн гүйцэтгэх Захирал Б.Баттулга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогийн хэлтсийн дарга С.Уранцэцэг, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Д.Гансүх болон бусад албаны хүмүүс оролцлоо. Мөн "МАК Цемент" компанийн гүйцэтгэх Захирал Б.Баттулга аймгийн Засаг даргатай цаашид орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аймгийн нутаг дэвсгэрт эрчим хүч, дэд бүтцийн салбарт хэрэгжүүлэх аж үйлдвэрийн болон орон сууцны томоохон төсөл, хөтөлбөрийн хэрэгцээнд шаардагдах цемент, зуурмаг хангах нийлүүлэх, Хөх цавын Цемент, шохойн үйлдвэрт шаардагдах ажлын байр, тавигдах шаардлагын талаар тухай бүр аймгийн иргэдэд зарлан мэдээллэж байх талаар хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Цаашид "МАК Цемент" компани 200 гаруй ажлын байранд орон нутгийн иргэдийг ажилд шалгаруулж авах юм байна.

# БОРЖИГИН ТҮМНИЙ ДЭЛГЭР САЙХАН НААДАМ...



Н.БАТЗАЯА
Б.ДАВААХҮҮ

Хаврын салхинд элэгдсэн байгаль дэлхий сая нэг нуруугаа амраан өнгө засч, нүд эрээлжлэм алаг цэцэгс түүнийг улам чимжээ. Нар өмнөхөөсөө ч илүү хурц туяагаа гялбуулан гийж, булгийн ус сэрүү татуулан хоржигнон урсах нь зуны налгар цаг ирснийг илтгэнэ. Айлын бор жаалууд "гийнгоо" түрэн уралдаж, нар шингэхтэй зэрэгцэн үнээ, тугал мөөрөлдөж, өөрийг нь тойрон эргэх шумуулыг сүүлээ шарван үргээж харагдана. Морины зэл тойрон цог хийморьтой харчууд дуу шуу нэмж, уясан эзэн, унасан хүүхдээ баярлуулах шандаст хурдан хүлгүүд хааяахан янцгаана. Басхүү сунгаанаас ирсэн жаалууд ам булаалдан унасан хүлгээ магтаж, наадмын түрүүг авна хэмээн маргалдах нь тун ч хөөрхөн. Энэ дэлхийн хаанаас ч хайгаад олохгүй ийм л сайхан зураглал ойрын өдрүүдэд эх орны минь өнцөг булан бүрт үргэлжилж буй. Улсын баяр наадмаас гадна дүүрэг, аймаг, сумд дор бүрнээ Тулгар төрийн 2226, Их Монгол Улсын 811, Ардын хувьсгалын 96 жилийн Үндэсний их баяр наадмаа хотол олноороо дэнж хотойтол дэлгэр сайхан тэмдэглэж байгаа билээ. Энэ үед Говьсүмбэр аймгийн наадам боллоо. Тодруулбал, энэ сарын 8, 9, 10-нд говьсүмбэрчүүд эрийн гурван наадмаа хотол олноороо өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлэв. Наадмыг нээж, Говьсүмбэр аймгийн Засаг дарга Г.Батсуурь "Хоёр мянганы түүхийг бүтээж, төрт ёс, есөн зууны ээзнт гүрнийг төвшитгөсөн ээзн Чингис хааныхаа алтан ургийг хаадын гал голомтыг өвлөн, тост Боржигины бор толгодынхоо дунд ажил хөдөлмөр, амжилт бүтээл, цэнгэл баяраар дүүрэн байгаа нутгийн зон олон та бүхэндээ Тулгар төрийн 2226, Их Монгол Улсын 811, Ардын хувьсгалын 96 жилийн Үндэсний их баяр наадмын халуун мэндийг өргөн дэвшүүлье. Монголчууд бид бэлгэтэй сайхнаа хэлэлцэж, ёс уламжлалаа дээдэлж, түүх шастираа хүндэтгэж, ард олныхоо амжилтаар бахархан, азай буурал ахмадууд, хойч үе хүүхэд багачууд, цаг цагийн түүхийг бүтээгчид үеүеийнхний хамтын их баяр цэнгэлийн нэг бол монгол наадам билээ. Нар хур тэгширсэн наадмын сайхан өдрүүдэд идэр чийрэг бөхчүүд маань хүчтэй, сүлд хийморийн даллага эргэмэг шандаст



хүлгүүд нь хурдан, цэц магнай харваачдын оноо зурхай нь мэргэн байж, дэнж хотлоороо дэлгэр сайхан наадаарай" гэв. Нээлтийн үйл ажиллагаанд УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга У.Бямбасүрэн, Говьсүмбэр аймгийн ИТХ-ын дарга Г.Батзам, Засаг даргын орлогч Ш.Билэггүмбэрэл, Засаг даргын Тамгын газрын дарга Д.Содном болон албаны бусад хүмүүс, нутгийн зон олон оролцлоо. Энэ үеэр УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэг "Нутгийнхаа зон олонд Үндэсний их баяр наадмын мэндийг өргөн дэвшүүлье. Аливаа улс орны тусгаар тогтнолын хамгийн үнэт баталгаа нь ардын их баяр наадам байдаг. Монгол түмнийг Азийн цээжинд наадмаа хийж байна хэмээн бахархан харж байна. 10 их ноёноо залж, агуу их түүхээ баталгаажуулж, алд цэнхэр хадгаа дэвсэж, ижий нар маань эв эеийг хурайлж байгаа ийм сайхан наадам биднээс өөр хаана ч зохиогдоогүй. Энэ утгаараа говьсүмбэрчүүд, боржигинчууд та бүхнээрээ бахархаж байна. Та бүхэн сайхан наадаарай" хэмээн наадамчин олонд мэндчилгээ дэвшүүлэв. Ийнхүү Боржигин түмний наадмын нээлтийн үйл ажиллагаа хэдэн зууны тэртээх боржигин овгийн үүсэл гарлыг танин мэдүүлсэн үзүүлбэрээр эхэлсэн юм.

**Үргэлжлэл нь X-XI нүүрт**

АМЖИЛТЫН ЭЗЭН

## Б.Батмөнх: БИ ҮНДЭСНИЙ СУРЫГ ӨӨРИЙГӨӨ ТАНИХ СЭТГЭЛЗҮЙН СПОРТ ГЭЖ БОДДОГ



Б.ДАВААХҮҮ

*Говьсүмбэр аймгийн баяр наадмын үндэсний сурын харвааанд 32 харваач 40 сум тавьж цэц мэргэнээ сорин өрсөлдсөнөөс тус аймгийн харьяат Усан спорт сургалтын төвийн аврагч багш, "Жахрай мэргэн" үндэсний сурын холбооны харваач, спортын мастер, аймгийн мэргэн Б.Батмөнх 26 оножь, хоёр дахь удаагаа түрүүлсэн юм. Харваачид онч мэргэнээ сорин өрсөлдөж, эхний сумаа тавих ахуйд аймгийн мэргэн Б.Батмөнхтэй цөөн хором ярилцсанаа хүргэе.*

**-Говьсүмбэр аймгийн баяр наадмын үндэсний сурын харвааанд хэчнээн харваач цэц мэргэнээ сорьж байна вэ?**

-Нийтдээ 32 харваач цэц мэргэнээ сорин өрсөлдөж байна. Тэдгээр харваачдын тав нь спортын мастер, хоёр нь спортын дэд мастер, аймгийн мэргэн спортын мастер хоёр, аймгийн мэргэн цолтой гурван харваач оролцов. Мөн өсвөрийн 10 гаруй харваач оролцож байна. Цаашид өсөх ирээдүйтэй, улсын наадамд сум тавиулж үзэх хоёр, гурван залуу харваач бий. Гэхдээ аймгийн наадам улсынхтай давхацсан учраас хот руу явж амжсангүй.

**-Наадмын өмнөх бэлтгэлээ хэрхэн базаадаг вэ. Үндэсний бөх шиг гал болж, хөдөө бэлтгэл хийдэг үү?**

-Аль ч аймгийн харваачид гал галаараа хөдөө бэлтгэлд гардаг болсон. Бидний хувьд Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд ажилладаг 10 гаруй харваачийн хамт Хаялга нуур руу цөөн хэд хоногийн бэлтгэлд гарсан. Үндсэн бэлтгэл долоо хоног, хоёр талд ээлжилсэн бэлтгэл ерөнхийдөө хавраас хойш үргэлжилсэн.

**Үргэлжлэл нь XI нүүрт**

# БОРЖИГИН ТҮМНИЙ ДЭЛГЭР САЙХАН



**Үргэлжлэл. Түрүүч нь IX нүүрт**

Мөн наадмын нээлтийн нэгэн онцлог нь Боржигин морин хуурыг Засаг дарга Г.Батсуурьт гардуулан 99 ээжээр аравнайлуулсан явдал байлаа. Түүнчлэн тус аймгийн төрийн байгууллага болон урлаг, спортын төлөөллүүд парадаар алхан наадамчин олонд хүндэтгэл үзүүлэв.

## Шагналын хур буув

Тэртээ Бөртэ чоно, Гуамаралаас улбаатай Боржигин түмний наадамд ирсэн хүн бүр нээлтийн үйл ажиллагааны урлагийн тоглолтыг халуун алга ташилтаар мялааж байв. Наадмын нээлтийн үйл ажиллагааны үеэр аймаг, орон нутагтаа ажил хөдөлмөрөөрөө тэргүүлсэн хүмүүсийг шагнаж, урамшуулсан. Тодруулбал, Хөдөлмөрийн Гавьяаны Улаан тугийн одон хоёр, “Алтан гадас” одонгоор 11, Хөдөлмөрийн хүндэт медалиар 12, Цэргийн одонгоор хоёр иргэн тус тус энгэрээ мялаав. Манай сурвалжлах хэсэг Төрийн дээд шагнал хүртсэн хүмүүстэй уулзаж, баярт мөчийг нь хуваалцсан юм.

## Б.Нямсүрэн: Хөдөлмөрийг минь үнэлэн “Алтан гадас” одонгоор шагнасанд баяртай байна

*/Сүмбэр сумын иргэн/*

-Үндэсний уламжлалт баяр наадмын энэ сайхан өдөр Төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнагдсандаа маш их баяртай байна. Ард түмний хүүхдүүдийг сургах үйлсэд оруулсан хөдөлмөрийг минь төр өндрөөр үнэллээ. Би Сүмбэр суманд 1969 оноос эхлэн бага ангийн багшаар 30 гаруй жил ажиллаад тэтгэвэртээ суусан. Ингээд нутгийнхаа зон олонд Ардын хувьсгалын баярын мэнд хүргэе.

## Б.Сосорбарам: Миний амжилт бол хамт олны минь амжилт

*/Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлгийн сувилагч/*

-Би эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй 35 жил ажиллаж, Төрийн хүндэт медаль авч байгаадаа баяртай байна. Миний энэ амжилт бол хамт олны минь амжилт. Тиймээс хамт олондоо баярлалаа гэж хэлье. Би анх 1983 онд Сүмбэр сумаас ажлын гараагаа эхлэж байлаа. Тухайн үед 10 гаруй хүнтэй ажиллаж байсан. Одоогийн байдлаар нэгдсэн эмнэлэг болон өргөжиж, 130 гаруй ажилтантай болжээ.

## Наадамчин олонд зориулж, монгол эмээлийн үзэсгэлэнг гаргасан гэв

Дүүрэг, сум, аймгийн наадамд зориулан тухайн орон нутгийн байгууллагууд асар босгон наадамд хүрэлцэн ирсэн хүн бүрийг айраг, чанасан махаар дайлж, наадмын өнгө төрхийг шинжин баярладаг уламжлалтай. Үүний нэгэн адил Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд ч гэр барин наадамчин олонд өөрсдийн ажлаа танилцуулж байлаа. Тэдний нэг бол Говьсүмбэр аймгийн музейн хамт олон. Уг хамт олон наадамчин олонд зориулж, монгол эмээлийн үзэсгэлэнг дэлгэжээ. Үзэсгэлэнд нийт 10 гаруй эмээлийг дэлгэн үзүүлэв. Энэ талаар Боржигин өв музейн эрдэм шинжилгээний ажилтан Т.Болдбаатараас тодруулахад “Ардын хувьгалын 96 жилийн ой, Говьсүмбэр аймгийн наадмаар бид монгол эмээлийн үзэсгэлэнг гаргаад байна. Үзэсгэлэнд зөвхөн боржигин удмын эмээл гэлтгүй аймгийнхааардиргэдийнэдэлж, хэрэглэж байсан, үе уламжилж ирсэн ховор нандин эмээлийг дэлгэлээ. Нийт 10 гаруй эмээл цугларсан. Тухайлбал, хүүхдийн эмээл, эмэгтэй эмээл гэх мэтчилэн олон төрлийн эмээл бий. Гэхдээ цаг гаргаад илүү судалгаа явуулбал илүү олон эмээл цуглах юм билээ. Энд дэлгэгдсэн эмээлийн хамгийн үнэтэй нь 80 сая төгрөгөөр үнэлэгдэнэ” гэв.

## Ц.Энхбат: Хүүхэд, залуучууд шагайн харвааг сонирхон хичээллэж байна

*Наадмын нэг хэсэг болох шагайн харвааны дүн хараахан гараагүй байхад манай сурвалжлах хэсэг Говьсүмбэр аймгийн Шагайн харвааны холбооны тэргүүн Б.Энхбаттай цөөн хором ярилцсанаа хүргэе.*

**-Шагайн харвааны тэмцээн хэр явагдаж байна вэ?**

-Говьсүмбэр аймгийн баяр наадмын шагайн харвааны тэмцээн амжилттай явагдаж, өндөрлөх шатандаа ороод байна. Одоогийн байдлаар багийн шигшээ харвааны тэмцээн үргэлжилж байна. Харваачид нэлээд ширүүн өрсөлдөөнтэй байгаа учраас сүүлийн харваа явагдаж байна. Энэ харвааны дараа ямар баг хэддүгээр байранд орсон нь тодорхой болох юм. Энэ жилийн баяр наадмын шагайн харвааны тэмцээнд нийт есөн багийн 90 гаруй харваач оролцлоо. Тухайлбал, Монгол Улсын Үлэмж дархан мэргэн Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын уугуул Б.Буянтогтох, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харьяат С.Энхбаатар зэрэг харваачид оролцлоо. Энэ жилийн харваа нэлээд өрсөлдөөнтэйболлоо. Харвааны дараа аймгийн гоц мэргэний цолыг 5-6 харваач хангахаар харагдаж байна. Гэхдээ тэмцээн арай дуусаагүй учраас хэн нь хэддүгээр байранд орох нь тодорхойгүй боловч медальт байранд орсон нь гоц мэргэний цолыг хангана гэж ойлгож болно.

**-Танай аймагт сүүлийн үед шагайн харваа эрчимтэй хөгжих болсон гэсэн. Хүүхэд, залуучууд хэр зэрэг сонирхон хичээллэж байна. Холбооны зүгээс ямар ажил хийж байна?**

-Шагайн харваа анх үүсэхдээ өрж тоглох буюу нэг баг 32 хасаанд өрж тоглож байлаа. Орчин цагт тулаа хасаа буюу хоёр хасаанд сум тавьдаг болсон нь залуу үеийн харваачдыг нэлээд орхигдуулсан. Одоо дахин өрж тоглож байна. Ингэснээр залуу харваачид болон хүүхдүүд их сонирхон харваж байна. Тулаа хасаанд тоглоход нэг багт зургаан харваач тоглодог. Өрөө хасаанд нэг багт долоон харваач тоглоно. Энэ нь илүү олон хүн шагайн харвааг сонирхон хичээллэх болсон нь харагдаж байна. Манай аймгийн хэмжээнд байнгын бэлтгэл сургуулилттай, тэмцээн уралдаанд идэвхтэй оролцдог 100 гаруй харваач бий. Мөн эхлэн суралцаж байгаа хүүхэд, залуучууд ч бий.

**-Шагайн харвааг хөгжүүлэхэд орон нутгийн удирдлагын зүгээс дэмжиж байна уу?**

-Манай аймгийн удирдлагууд шагайнхарваагмаш ихдэмждэг. Манай шагайн харвааны холбоо маань өөрсдийн гэсэн байртай. Түүндээ шагайн харвааны клуб ажиллуулдаг. Өдөр бүр харваж, бэлтгэл сургуулилт хийж, залуу үеэ бэлтгэж байна. Сүүлийн үед сургуулийн насны хүүхдүүд шагайн харвааг сонирхох болсонд их баяртай байгаа.

Тэрбээр ийн ярьсан юм. Тулгар төрийн 2226, Их Монгол Улсын 811, Ардын хувьсгалын 96 жилийн ой, Говьсүмбэр аймгийн баяр наадмын шагайн харвааны тэмцээнд гурван аймгийн зургаан сумын есөн багийн 85 харваач оролцож, онч мэргэнээ сорин өрсөлдөв. Нэг хүн бүрийн цуваа харваанд Тэргүүн байрыг И.Түнжинбаатар, дэд байранд Ж.Түвшинзаяа, гутгаар байранд М.Амарбаясгалан орсон бол ахмадын бууны цуваа харваанд тэргүүн байрыг Б.Буянжаргал, дэд байрыг Ж.Равжаа, гутгаар байрыг н.Даваасүрэн нар тус тус эзэлсэн байна. Харин багийн тэмцээнд тэргүүн байрыг Н.Идэржавхлан ахлагчтай “Чойр зангилаа” баг шалгарсан бол дэд байрыг Д.Мөнхбат ахлагчтай “Буяны гэгээ” баг, гутгаар байрыг Ж.Түвшинзаяа ахлагчтай “Говьсүмбэр” баг эзэлжээ.

## Говьсүмбэр аймгийн харьяат сумын заан Э.Мөнхбаатар түрүүлж, аймгийн арслан боллоо

Үндэсний их баяр наадмыг хүчит бөхгүйгээр төсөөлөхийн аргагүй. Тиймээс ч үе үеийн наадмын бөхийн асар наадамчин олны уухайн түрлэгт тэтгэгдэн байдаг биз ээ. Энэ жил Говьсүмбэр аймгийн хүчит бөхийн барилдаанд нийт 256 бөх үнэн хүчийг үзэн барилдахаар бүртгүүлжээ. Энэ тухай Говьсүмбэр аймгийн баяр наадмын комиссын дарга Ш.Билэггүмбэрэл хэлэхдээ “Ардын хувьсгалын 96 жил, Говьсүмбэр аймгийн баяр наадам амжилттай зохион байгуулагдаж байна. Нар хур тэгширсэн сайхан наадам болж байна. Наадмын нэг онцлог нь аймгийн Баяр наадмыг зохион байгуулах Хороо болон Үндэсний бөхийн салбар хороодын шийдвэрээр улсын цолтон болон аймгийн хурц арслан цолтой бөхчүүдийг барилдуулахгүй байхаар шийдвэрлэсэн. Уг шийдвэрийн хүрээнд аймгийн арслан цолноос доош цолтой бөхчүүд эр бяраа гайхуулан сайхан барилдаж байна” гэв. Ардын хувьсгалын 96 жилийн ой, Говьсүмбэр аймгийн баяр наадмын Үндэсний бөхийн барилдаанд тус аймгийн Сүмбэр сумын харьяат сумын заан Э.Мөнхбаатар найм даван түрүүлж, “Аймгийн арслан” цол хүртэж, нутгийн зон олноо баярлууллаа. Үзүүрт Булган аймгийн Гурванбулаг сумын харьяат аймгийн харцага П.Даваадорж шалгарч, “Аймгийн заан” цол хүртсэн бол Булган аймгийн Орхон сумын харьяат аймгийн шилдэг заануудын нэг Б.Түмэндэмбэрэл, Булган аймгийн Могод сумын харьяат аймгийн заан Э.Энх-Амгалан нар шөвгийн дөрөвт шалгарав. Мөн Төв аймгийн Бүрэн сумын харьяат, сумын заан Б.Дэлгэрдалай, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын харьяат, сумын заан Э.Батмагнай, Ховд аймгийн Зэсэг сумын харьяат, сумын заан Д.Уламсайхан, Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын харьяат, сумын заан Б.Цэрэндагва нар тав давж, “Аймгийн начин” цолны болзол хангалаа. Түүнчлэн Говьсүмбэр аймгийн баяр наадмын хүчит бөхийн барилдааныг чимсэн нэгэн нь үйл явдал нь өсвөрийн бөхчүүдийн барилдаан байв. Өсвөрийн бөхийн барилдаанд 32 бөх барилдаж, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харьяат, Нэгдүгээр сургуулийн сурагч Х.Ган-Очир түрүүлж, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харьяат, Улаанбаатар хотын 59 дүгээр сургуулийн сурагч М.Тэмүүлэн үзүүрлэжээ. Харин Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харьяат, Нэгдүгээр сургуулийн сурагч З.Мөнх-Эрдэнэ, З.Булгантамир нар шөвгийн дөрөвт шалгаран үлдсэн юм.

## Эрлийз морьдыг тусад нь уралдуулахаар шийдвэрлэжээ

Говьсүмбэр аймгийн Баяр наадмын комисс энэ жил эрлийз насны морьдыг тусад нь уралдуулахаар шийдвэрлэсэн нь наадамчин олны талархлыг хүлээж байлаа. Жил бүрийн наадмаар эрлийз морийг монгол морьдтой хамт уралдуулснаас болж багагүй хэл ам гардаг байжээ. Харин энэхүү асуудлыг шийдвэрлэсэн нь наадамчин олны сэтгэлийг баясгаж байв. Эрлийз хурдан морьдын уралдаанд газар газраас ирсэн шанадаст хурдан хүлгүүд тоосоо өргөлөө. Аймгийн баяр наадмын Эрлийз хурдан морьдын дээд нас буюу азарга, их нас, соёолонгийн морьдын уралдаанд Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын уяач М.Алтангэрэлийн хээр түрүүлж, аман хүзүүнд Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын уяач Б.Бүүвэйхүүгийн хээр, айргийн гуравт Дундговь аймгийн Баянжаргалан сумын харьяат Сумын алдарт уяач Б.Сумъяадоржийн сартай зээрд, айргийн дөрөвт Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын уяач Б.Бүүвэйхүүгийн сартай хээр, Дорноговь аймгийн Даланжаргалан сумын харьяат сумын алдарт уяач О.Алтансүхийн бор халзан айргийн тавд хурдалсан байна. Харин эрлийз хурдан морьдын дунд нас буюу шүдлэн, хязаалан морьдын уралдаанд Төв аймгийн Баяндэлгэр сумын уяач Г.Дашзэвэгийн хээр халзан түрүүлж, аман хүзүүнд Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын уяач А.Сугарын буурал халзан, айргийн гуравт Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын уяач н.Ганхүүгийн цавьдар халзан, дөрөвт Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын уяач Б.Баттөмөрийн зээрд халзан, айргийн тавд Төв аймгийн Эрдэнэ сумын уяач Д.Бямбацогтын хул оржээ. Мөн Эрлийз хурдан морьдын бага нас буюу дааганы уралдаандГовьсүмбэраймгийн Сүмбэр сумын тавдугаар багийн харьяат Ц.Мөнхбатын бор зүсмийн даага түрүүлж, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын уяач Б.Билэгжаргалын зоос бор аман хүзүүнд, айргийн гуравт Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын дөрөвдүгээр багийн уяач Г.Төмөрбаатарын сартай хээр, айргийн дөрөвт Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын зургадугаар багийн уяач Д.Баатарын бор, айргийн тавд Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын VI багийн уяач Г.Одсүрэнгийн бор халзан зүсмийн даага орж, наадамчин олноо баясгалаа. Ингээд хурдан морины уралдааны айргийн тавын дэлгэрэнгүй мэдээллийг хүргэе.

### Азарганы уралдаан

I - Дундговь аймгийн Өнөршил сумын харьяат, уяач Ш.Нармандахын хээр
II - Говьсүмбэр аймгийн Баянтал сумын харьяат, уяач Г.Баярмагнайн сартай хүрэн
III - Улаанбаатар хот Хан-Уул дүүргийн харьяат, уяач Ч.Батсайханы шарга халзан
IV - Дундговь аймгийн Өндөршил сумын харьяат, уяач С.Найманжингийн хүрэн
V - Дундговь аймгийн Өнөршил сумын харьяат, уяач Ш.Нармандахын бор

### Их насны морьдын уралдаан

I - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харьяат, уяач Ө.Алтан-Очирын хээр
II - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харьяат, уяач Ц.Энхжаргалын сартай хүрэн
III - Говьсүмбэр аймгийн



Реклам, зар сурталчилгааны алба: 99173710

# ГОВЬСҮМБЭРИЙН МЭДЭЭ

## НААДАМ...

Сүмбэр сумын харьяат, уяач М.Насанбуянгийн бор
IV - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харьяат, уяач Л.Жамбаасүрэнгийн бор
V - Дундговь аймгийн Өндөршил сумын харьяат, уяач Ё.Дашжамцын хүрэн халзан

### Соёолонгийн уралдаан

I - Говьсүмбэр аймгийн Баянтал сумын харьяат, уяач Г.Баярмагнайн сартай хүрэн
II - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын III багийн харьяат, уяач Л.Жамбаасүрэнгийн хонгор
III - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын V багийн харьяат, уяач С.Баттөрийн хүрэн
IV - Дундговь аймгийн Өндөршил сумын харьяат, уяач Т.Дөлгөөний зээрд
V - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын V багийн харьяат, уяач Ц.Мөнхжаргалын зээрд

### Хязаалангийн уралдаан

I - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын VI багийн харьяат, уяач О.Ягаанаагийн хар
II - Дундговь аймгийн Дэрэн сумын харьяат, уяач Б.Ширчинжавын зээрд
III - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум III багийн харьяат, уяач П.Амарсайханы хээр
IV - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын IV багийн харьяат, уяач Ч.Энхбатын хонгор
V - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын VI багийн харьяат, уяач Г.Одсүрэнгийн хүрэн халзан

### Шүдлэн насны морьдын уралдаан

I - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харьяат, уяач Ц.Мөнхжаргалын хүрэн
II - Дундговь аймгийн Даланжаргал сумын харьяат, уяач Э.Дэмчигнямын хамар цагаан хар
III - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харьяат, уяач А.Төмөөгийн хээр
IV - Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын харьяат, уяач С.Ганхүүгийн зээрд
V - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харьяат, уяач Ж.Наранбаатарын хүрэн халзан

### Дааганы уралдаанд:

I - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нэгдүгээр багийн харьяат, уяач Б.Мөнхтүмэнгийн хээр
II - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын II багийн харьяат, уяач П.Эрдэнэзаяагийн зээрд
III - Говьсүмбэр аймгийн Баянтал сумын харьяат, уяач Г.Баярмагнайн сартай хүрэн
IV - Дундговь аймгийн Өндөршил сумын харьяат, уяач Т.Дөлгөөний хонгор
V - Говьсүмбэр аймгийн Баянтал сумын харьяат, уяач Ц.Доржсүрэнгийн бор

### Аймгийн мэргэн С.Туяагэрэл хоёр дахь удаагаа сурын харвааг өнгөлөв

Эрийн гурван наадмын нэг бол сурын харваа. Эртнээс нүүдэллэн амьдарч ирсэн монголчуудалдарцуутай мэргэн харваачид байсан билээ. Өвөг дээдсээс ирсэн сурын харваа эдүгээ хүртэл уламжлагдан эрийн гурван наадмын нэг, спортын нэгэн төрөл болтлоо өргөжин хөгжсөн. Тэгвэл Говьсүмбэр аймгийн баяр наадмын Үндэсний сурын харваанд нийт 32 харваач цэц мэргэнээ сорин өрсөлдлөө. Эрэгтэйчүүдийн харваанд Говьсүмбэр аймгийн харьяат Усан спорт сургалтын төвийн аврагч, багш, "Жахрай мэргэн" үндэсний сурын холбооны харваач спортын мастер, аймгийн мэргэн Б.Батмөнх хоёр дахь удаагаа түрүүллээ. II байрт "Жахрай мэргэн" үндэсний сурын холбооны харваач спортын мастер А.Пүрэвсүрэн орж,"Аймгийн гарамгай мэргэн" цол хүртсэн юм. Харин III байрт Онцгой байдлын газар, "Жахрай мэргэн" үндэсний сурын холбооны харваач спортын мастер, аймгийн мэргэн Т.Батхуяг шалгарав. Эмэгтэйчүүдийн харваанд Сүмбэр сумын нэгдүгээр цэцэрлэгийн эрхлэгч, "Жахрай мэргэн" үндэсний сурын холбооны харваач аймгийн мэргэн С.Туяагэрэл хоёр дахь удаагаа түрүүлсэн бол II байрт Уул уурхайн жишиг сургууль Политехник коллежийн багш, "Жахрай мэргэн" үндэсний сурын холбооны харваач спортын мастер Ж.Норжмаа шалгарч, "Аймгийн гарамгай мэргэн" цол хүртэв. Харин Өмнөговь аймгийн харваач н.Отгонцэцэг III байрт шалгарч, "Аймгийн гоц харваач" цолны эзэн боллоо.

Өнгө өнгийн дээлтэй өвгөд хөгшид хуушуурын гэрт дугаарлаж, шаргал дурдан бүсээ тэвхийтэл нь бүсэлсэн залуус соёолонгийн тоосонд химморио сэргээн, өвгөд бууруулд хүчит бөхийн барилдаанд давсан бөхийг тэнхээ мэдэн дэмжих нь ёстой л хэн хүний хүлээсэн наадам гэлтэй. Удаан хүлээсэн наадам болоод ч тэр үү наадмын нээлтийн үйл ажиллагаа хүртэл сэтгэл зүрхэнд үлдэх нь хэмжээ залуус хөөрөлдөнө. Сэтгэлд тодхон үлдэхээс өөр аргагүй наадмын үзүүлбэрээр нээлтийн үйл ажиллагаа эхэлсэн болохоор тэр биз. Энэ удаагийн наадмыг найруулсан Боржигин чуулгын найруулагч Т.Батсэрээтэр залуучуудаа өвөг дээдсийнхээ түүх соёлыг танилцах, бахархах сэдлийг төрүүлэхийг зорьсон хэмээн онцолж байлаа. Хүчит бөхийн барилдаанд хөгжиж, шагай, сурын харвааанд сэтгэл баясч, унаач хүүгийн гийнгоон дуунд бүүвэйлэгдсэн Говьсүмбэр аймгийн наадамүдшийн шоугаар үргэлжилсэн. Наадмын шоу арга хэмжээнд "Fire" хамтлаг, "Эмоци" продакшны жүжигчин Алтан-Өлзий хүрэлцэн ирж, наадамчин түмэнтэй нэгэн үдшийг доргио өнгөрүүлснээр энэ жилийн наадам өндөрлөлөө. Дараа жилийн наадам даанч хол байна даа.

АМЖИЛТЫН ЭЗЭН



## Б.БАТМӨНХ:
## Би үндэсний сурыг өөрийгөө таних сэтгэлзүйн спорт гэж боддог

Үргэлжлэл.
Түрүүч нь IX нүүрт

**-Үндэсний сурын харвааг сонирхон хичээллэж буй харваачид ихэвчлэн өөр өөр ажил эрхэлдэг хүмүүс байдаг юм билээ. Говьсүмбэр аймгийн тухайд үндэсний сурын холбоотой гэж сонсч байсан юм байна?**

-Төрийн алба хаагчид, уурхайн ажилтнууд, цагдаа хүчний байгууллагын алба хаагчид гэхэд дор бүртээ эрхэлсэн ажилтай хүмүүс байдаг. Чөлөөт цагаараа хобби маягаар хөгжүүлдэг гэж хэлж болно. Харин мэргэжлийн тамирчин бэлтгэх зорилгоор "Жахрай мэргэн" үндэсний сурын холбоо байгуулагдсан юм. Холбоо үйл ажиллагаагаа явуулж эхлээд зургаан жил болж байна. Холбооны нэрийн дор бэлтгэл сургуулилтад гардаг, харвадаг харваачид бий.

**-Холбоо байгуулагдсанаас хойш гаргасан амжилтаас дурьдахгүй юу?**

-Энэ хугацаанд 10 гаруй спортын мастер, зургаан аймгийн мэргэн цолтон төрөн гарсан.

**-Залуу үеэ бэлтгэх тал дээр хэр анхаарч байна вэ?**

-Говьсүмбэр аймгийн хоёрдугаар сургууль "Үндэсний өв соёлыг дэлгэрүүлэх" гэх хөтөлбөр хэрэгжүүлж, дэргэдээ дугуйлан ажиллуулж эхэлсэн. Анх 100 гаруй хүүхэд бүртгүүлсэн байдаг. Орон нутгийн нэг онцлог нь зун болохоор ихэнх хүүхэд амраад хөдөө гэр рүүгээ явчихдаг. Тиймээс зуны бэлтгэл алдагдчихдаг юм. Хоёрдугаар сургуультайгаа хамтраад залуу харваачдаа бэлтгэх, үндэсний өв соёлоо дэлгэрүүлэх чиглэлд дорвитой ажил хийж байна. Хөтөлбөр өнгөрсөн өвлөөс хэрэгжиж эхэлсэн.

**-Тэгэхээр зуны бэлтгэл чухал гэсэн үг байх нь ээ?**

-Хамгийн чухал. Орчин нөхцөлд нь харваж байж жинхэнэ харваач болно шүү дээ. Сэтгэлзүйн хувьд ч танхимд болон талбайд бэлтгэл хийх тэс өөр. Тэмцээн ч гэсэн сэтгэлзүйн өөрчлөлт орж ирнэ. Орчинд нь орж, тэр бүрийг мэдэрч байж л харваач болно.

**-Та хэдий үеэс үндэсний сурын харваатай холбогдож эхэлсэн бэ?**

-Би 2006 оноос сурын харваагаар хичээллэж, 2008 оноос тэмцээн уралдаанд оролцож эхэлсэн. Анх 2009 онд аймгийн мэргэн цол хүртэж, 2014 онд спортын дэд мастер, 2015 онд спортын мастер цол авсан.

**-Та яагаад үндэсний сурын спортыг сонирхон хичээллэх болсон юм бэ?**

-Ер нь багаасаа л сонирхдог байсан. Гэхдээ хэрэглэл материалыг нь захын дэлгүүрээс авчихдаггүй болохоор нөхцөл боломж муу байсан хэрэг. Харин зургаан 20 гарсан хойно, ах маань харваж сурсан юм. Тэр үед ахыгаа дагаж Өмнөговь аймгийн харьяат Буяндэлгэр багштайгаа танилцаж билээ. Тэр хүн л намайг үндэсний сурын спорт руу "уруу татаж", зааж сургасан.

**-Ахаас тань өөр танай гэр бүлд харваач бий юу?**

-Манай гэр бүлийн хүн сур харвадаг. Бас спортын мастер цолтой. Политехникийн коллежид монгол хэл, уран зохиолын багшаар ажилладаг бүсгүй бий. Хүүхдүүдийн маань том нь зургаан настай. Харвахад арай л багадаад байгаа юм. Эмэгтэй хүүхэд учраас том болохоороо үндэсний сурын харваагаар хичээллэх эсэхээ өөрөө шийднэ биз, хүчлэхгүй. Боломжийг нь бүрдүүлж өгнө, дараагийн асуудлыг охины маань сонирхол л шийдэх байх.

**-Та одоо аймгийн мэргэн цолтой шүү дээ. Дараагийн цол нь ямар цол байдаг юм бэ?**

-Аймагтаа хоёр удаа түрүүлбэл хошой мэргэн, гарамгай мэргэн гэх мэтээр чимэг нэмээд явна. Улсын баяр наадмын гуравт орсон харваач гоц, хоёрт орсон нь гарамгай, түрүүлсэн харваач улсын мэргэн цол авдаг. Улсын мэргэн дахиад түрүүлбэл чимэг нэмээд явдаг. Тэгэхээр ерөнхийдөө улсын наадмын эхний гурван байрт орж байж л улсын цол хүртэнэ гэсэн үг. Спортын мастер, аймгийн мэргэн гэсэн цол маань үндэсний сурын спортод эрэмбэлэгдэж байгаа.

**-Танд улсын наадамд оролцох төлөвлөгөө бий юу?**

-Энэ жил улсын наадамд оролцох сонирхолтой байсан ч, хугацаа нь давхацчихлаа. Ирэх жилээс хугацаа зөрж таарвал, хугацаа зөрөхгүй ч бэлтгэл сайн байвал оролцоно. Бэлтгэлээ л харж байж болно. Улсын наадамд амжилт гаргаж, улсын цолонд хүрэх гэсэн зорилго байлгүй яах вэ.

**-Та хамгийн анхны наадмын дурсамжаасаа хуваалцаач?**

-2006 онд "Боржигин наадам" болсон юм. Тэнд улсын мэргэн Өлзийбат анх намайг өөрийнхөө нумаар сум тавиулж байлаа. Өмнө нь таньдаг, ойр дотно харилцаатай байсан юм. Би ч нэлээд сонирхоод, саваагүйтээд л нум сумыг нь бариад явдаг байсан. Одоо бурхан болсон доо. Тэгэхэд, 20 сум тавиад, нэг л онож билээ. Наадамд анх удаа харвасан нь тэр. Түүнээс хойш нэг оносон гэж шантраагүй. Илүү олон онодог болохыг тулд хичээж, бэлтгэл хийж эхэлсэн.

**-Үндэсний сурын бусад спортоос ялгарах онцлог нь юу байдаг юм бэ. Тэсвэр тэвчээрийн спорт ч гэж нэрлэх нь бий. Харин таны тухайд?**

-Өөрөө өөрийгөө таньж, ойлгоход тусалдаг сэтгэлзүйн спорт гэж боддог. Яг харвах мөчид гар, толгой, хөлийн байрлалаа бодож тунгааж, өөрийгөө ойлгож, өөртэйгөө, доторхүнтэйгээяръжхарвадаг. Эрэгтэй хүн 75, эмэгтэй хүн 65 метрээс харвадаг. 75 метрийн цаанаас нэг мм-ийн л алдаа гаргахад метрийн алдаа болж очно гэсэн тооцоо бий. Дээр нь салхиа тооцно. Монгол нумыг янгирын эвэр, бод малын шөрмөс тавьж хийдэг учраас нар гармагц зөөлөрч, хүйтэрмэгц хатуурдаг. Тэгэхээр нумнаасаа хувирлыг мөн тооцно.

> ...Өөрөө өөрийгөө таньж, ойлгоход тусалдаг сэтгэлзүйн спорт гэж боддог. Яг харвах мөчид гар, толгой, хөлийн байрлалаа бодож тунгааж, өөрийгөө ойлгож, өөртэйгөө, дотор хүнтэйгээ ярьж харвадаг. Эрэгтэй хүн 75, эмэгтэй хүн 65 метрээс харвадаг. 75 метрийн цаанаас нэг мм-ийн л алдаа гаргахад метрийн алдаа болж очно гэсэн тооцоо бий. Дээр нь салхиа тооцно...

# ГОВЬСҮМБЭРИЙН НААДАМ



























Реклам, зар сурталчилгааны алба: **99173710**